

А ХЭСЭГ: ТАНИЛЦУУЛГА БА ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

БҮЛЭГ А2: БОДЛОГО БА ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

АГУУЛГА

2. БОДЛОГО БА ХУУЛЬ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	3
2.1 БҮЛГИЙН ТОЙМ	3
2.2 ҮНДСЭН ХУУЛЬ	3
2.3 ЗАСГИЙН ГАЗАР	3
2.3.1 Үндэсний болон бүс нутгийн засаг захиргаа	3
2.3.2 Шүүх тогтолцоо	4
2.4 ХУУЛЬ ТОГТООМЖ	4
2.4.1 Оршил	4
2.4.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	4
2.4.3 Байгаль орчныг хамгаалах	4
2.4.4 Газар, газар ашиглалт ба газар ашиглах эрх цуцлах	5
2.4.5 Ашигт малтмалын тухай хууль	7
2.4.6 Усны тухай хууль	8
2.4.7 Агаарын бохирдлын тухай хууль	9
2.4.8 Хог хаягдал болон аюултай бодисууд	9
2.4.9 Соёлын өв	10
2.4.10 Байгаль орчны төлбөр	10
2.4.11 Эрүүл мэнд ба аюулгүй байдал	10
2.4.12 Хөдөлмөрийн тухай хууль	11
2.5 МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТУУД	12
2.6 ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭРҮҮД	15
2.6.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	15
2.6.2 Ургамал, амьтны аймгийн хамгаалалт	16
2.6.3 Биологийн төрөл зүйлийн олон янз байдал ба тогтвортой хөгжил	17
2.6.4 Эрчим хүч ба уур амьсгалын өөрчлөлт	17
2.6.5 Озоны давхаргыг устгах бодисууд	17
2.6.6 Аюултай бодисууд	18
2.6.7 Ус	18
2.6.8 Хог хаягдал	18
2.6.9 Дуу чимээ	18
2.6.10 Биет ба биет бус соёлын өв	18
2.6.11 Хөдөлмөрийн харилцаа ба ажилчдын эрх	19
2.6.12 Мал аж ахуйн үйлдвэрлэл	19
2.7 ОЮУ ТОЛГОЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ	19
2.7.1 Оршил	20
2.7.2 Үндсэн үйл ажиллагаа	20
2.7.3 Бүсийн хөгжил	20
2.7.4 Байгаль орчин	21
2.7.5 Дэд бүтэц	23
2.7.6 Хөдөлмөрийн харилцаа, ажил эрхлэлт ба сургалт	24
2.7.7 Засгийн газрын нэмэлт үүрэг амлалтууд	24
2.8 ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА	25
2.8.1 ОУСК-ийн шаардлагууд	25
2.8.2 Европын сэргээн босголт хөгжлийн банкны шаардлагууд	28
2.8.3 ЭЗХАХБ-ын Байгаль орчны нийтлэг хандлагуудын талаар болон албан ёсоор дэмжигддэг экспортын зээлүүдийн талаар өгсөн зөвлөмжүүд	32
2.8.4 Экваторын зарчим	33
2.8.5 Стандарт Чартеред банкнаас уул уурхай ба металлургын салбарт санхүүжилт олгоход баримтлах байр суурийн талаарх мэдэгдэл	33

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 2.1: Оюу Толгой төслийн барилгын болон үйлдвэрлэлийн үе шатны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд..... 12

2. БОДЛОГО БА ХУУЛЬ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1 БҮЛГИЙН ТОЙМ

Энэ бүлэгт Оюу Толгойн төслийн үйл ажиллагаанд мөрдөх үндэсний болон олон улсын бодлого, хууль зүйн зохицуулалтыг тоймлон өгүүлсэн болно. Тус бүлэгт Монгол улсын бодлого ба хууль зүйн ерөнхий хүрээг байгаль орчин, газар ашиглалт, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа зэрэг салбаруудын хуулиудтай хамтад нь авч үзсэн юм. Хэдийгээр энэ бүлэгт байгаль орчны тухай хуулийг тоймлон авч үзсэн боловч, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбогдох хууль тогтоомжийг энэ тайлангийн *Бүлэг АЗ: Аргазүй*-д мөн тусгасан. Мөн түүнчлэн байгаль орчин, нийгмийн холбогдох стандартуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн суурь судалгааны бүлгүүдэд тусгасан болно (*Хэсэг В*).

Энэ бүлэгт дараах асуудлуудыг авч үзсэн:

- Монгол Улсын Үндсэн хууль ба Засгийн газар;
- Байгаль орчныг хамгаалах, ажилтны эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийн менежмент болон эд хөрөнгийн эрхтэй холбогдох Монгол улсын хууль тогтоомжийн тойм;
- Байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаатай холбогдох стандартуудын тойм;
- Холбогдох олон улсын гэрээ, хэлэцээрүүдийн тойм;
- Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний хураангуй (ХӨОГ); ба
- Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн байгаль орчин, нийгмийн асуудалтай холбогдох шаардлага, зааварчилгаанууд.

2.2 ҮНДСЭН ХУУЛЬ

Монгол улс нь 70 жилийн турш социалист системээр замнасны эцэст 1992 онд парламентын тогтолцоотой улс болсон билээ. Шинэ Үндсэн хуулийг Монгол Улсын Ардын Их Хурлаар 1992 оны 1-р сарын 13-нд баталсан. Үндсэн хуулиар Монгол Улсын Иргэний эрх, эрх чөлөөг тунхагласан ба түүнд *‘эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах’* (Үндсэн хуулийн 16.1.2.-) эрхтэй гэж заасан байдаг. Түүнчлэн төрийн эрх мэдлийг хуульчилан засаглалын эрх мэдэл болон хариуцлагыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл тус бүрээр тогтоож өгсөн юм.

2.3 ЗАСГИЙН ГАЗАР

2.3.1 Үндэсний болон бүс нутгийн засаг захиргаа

Монгол улс бол парламентын тогтолцоотой улс бөгөөд засаглалын босоо тогтолцоотой нэгдсэн улс учир Засгийн газар нь дээд эрх мэдэлтэй байх ба орон нутгийн засаг захиргааны нэгжүүд нь (аймаг, дүүргийн түвшний нэгжүүд) зөвхөн Засгийн газраас олгогдсон эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Засаглалын үндсэн цөм нь 76 гишүүнтэй, нэг парламентын танхим бүхий Улсын Их Хурал юм.

Монгол улсад Улсын Их Хурлыг оролцуулан засаглалын дөрвөн түвшин байдаг. Аймаг, дүүргийн түвшний засаглалын дээд түвшин нь аймаг болон нийслэл хот Улаанбаатар юм. Аймгууд нь бүс нутаг суманд, Улаанбаатар хот нь дүүргүүдэд хуваагддаг. Хамгийн доод түвшний засаглал нь хөдөөгийн хэсэг (баг) ба хотын хэсэг (хороо) гэсэн 2 хэсэгт хуваагдах юм. Нийтдээ 21 аймаг, 329 сум болон 1520 баг байдаг. Улаанбаатар хот нь 9 дүүрэг, 117 хороотой.

1992 оны Үндсэн хуулиар Монгол улсын засаг захиргааны нэгжүүдийг өөрөө удирдах болон төрийн удирдлагыг хослуулах зарчмын үндсэн дээр хэрэгжүүлэхээр хуульчилсан ба нэгж бүр өөрийн Засаг дарга болон Иргэдийн (төлөөлөгчдийн) хуралтай байдаг. Засаг дарга нь төрийн мөн орон нутгийнхаа төлөөлөгч бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн болон иргэдийн нийтийн хурлын гишүүдийг тухайн орон нутгийн иргэд сонгодог.

Монгол улс нь төрийн тэргүүн болох Ерөнхийлөгчтэй. Ерөнхийлөгчийг бүх ард түмний сонгуулиар сонгодог. Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын олонх болсон нам буюу эвслээс Ерөнхий Сайдад нэр дэвшигчийг санал болгодог.

2.3.2 Шүүх тогтолцоо

Үндсэн Хуулийн Цэц

Үндсэн хуулийн Цэц нь бие даасан байгууллага бөгөөд Үндсэн хуульд захирагддаг. Үндсэн Хуулийн цэц нь үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоох бөгөөд, үндсэн хуулийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэдэг.

Дээд Шүүх

Дээд Шүүх нь Монгол улсын хамгийн дээд түвшний шүүх байгууллага юм.

Хуулийн заалтын утга эсвэл хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар ямар ч хувь хүн, албан байгууллага Дээд Шүүхэд хандан тайлбар хүссэн өргөдлийг гаргаж болно.

Доод шатны шүүх байгууллагууд

2002 оны Шүүхийн Тухай Хууль нь шүүх системийн бүрэлдэхүүн болоод бүтцийг тогтоож, шүүгчдийн болон шүүхийн бие даасан байдлыг баталгаажуулсан юм. Монгол Улсын Дээд Шүүхийн доор аймаг, нийслэл хот, сум, сум дундын болон дүүргийн шүүхүүд ажилладаг.

2.4 ХУУЛЬ ТОГТООМЖ

2.4.1 Оршил

Доорх хэсэгт төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагаанд үйлчлэх хуулиудын талаар авч үзэх болно.

2.4.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 1998 оны 1-р сарын 22-нд батлагдсан ба 2001 оны 11-р сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон. Уг хуулийн талаар *БОННБУ-ний арга зүйн Бүлэг АЗ-т* дэлгэрэнгүй тусгасан. Энэхүү хуульд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хэрхэн боловсруулах явцад олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулах болон шаардлагатай мэдээллийг ил тод байлгах тухай заасан.

2.4.3 Байгаль орчныг хамгаалах

Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 оны 6-р сарын 5-аас эхлэн мөрдөгдөж эхэлсэн).

Энэхүү хуулийн зорилт нь тогтвортой хөгжлийн зарчмуудын дагуу байгаль орчны асуудлыг зохицуулахад оршино. Энэ хууль нь байгаль орчныг хамгаалах талаар баримтлах ерөнхий зарчим ба шаардлагуудыг тусгасан суурь хууль бөгөөд илүү нарийвчилсан асуудлыг бусад хуулиар зохицуулдаг. Түүнчлэн энэ хуулиар байгалийн нөөц ашигласны төлбөрийн тогтолцоог тодорхойлж өгсөн бөгөөд засаглалын бүх түвшинд байгаль орчны асуудлыг зохицуулах үүрэг хариуцлагын хуваарилалтыг тусгасан.

Оюу Толгой төсөл нь Монгол улсын Өмнийн Говийн бүсэд, Өмнөговь аймгийн Ханбогд суманд байрладаг. Оюу толгой нь үндэсний хэмжээний хууль тогтоомж, орон нутгийн түвшний буюу Өмнөговь аймаг болон Ханбогд сумын засаг захиргаанаас батлан гаргасан дүрэм журмуудыг мөрдөн ажилладаг.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь төсөлд хэрэгжих ерөнхий зарчмуудыг тодорхойлж төслийн бүсийн үйл ажиллагаануудыг зохицуулах бусад хуулиудын, тухайлбал: Төлбөрийн тухай хуулиудын хэрэгжилтэнд тус дэм өгдөг суурь хууль юм.

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997 оны 10-р сарын 23-наас мөрдөгдөж эхэлсэн).

Энэхүү хуулиар дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, урьдчилан сэргийлэх ба арилгах зорилгоор орчны бүсүүдийг байгуулах ёстой хэмээн заасан бөгөөд байгалийн нөөцийн зохистой ашиглалтын шаардлагыг тогтоосон байдаг. Уг хууль нь орчны бүс болон түүний хил хязгаарыг тогтоох шалгуурыг тусгайлан заасан ба Орчны бүсийн Зөвлөлийг байгуулан, түүний бүтэц ба үүрэг хариуцлагыг тогтоож өгсөн. Орчны бүсүүдийг хөгжүүлэх болон орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих үүднээс Орчны Бүсийн Санг бас байгуулсан. Мөн Хууль нь орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнүүд боловсруулалт ба Орчны

бүсийн хууль тогтоомжийн зөрчилд оногдуулах хариуцлагыг тусгасан. Говийн бага дархан цаазат газрын (ГБДЦГ) А ба В бүсүүдийг тойрсон орчны бүс байдаг.

Төслөөс Гашуун сухайтын хилийн боомт хүрэх зам нь ГБДЦГ-ыг дайран өнгөрдөг бөгөөд зам ашиглалт ба менежментэнд Тусгай хамгаалалтын газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн заалтуудыг дагаж мөрдөх болно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1995 оны 4-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон).

Энэ хууль нь газар нутгийн унаган төрх байдлыг хадгалах, ховордсон, устах аюулд өртсөн болон бусад төрөл зүйлийн ургамал амьтдыг хамгаалах зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтанд авах, ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Хуулиар дөрвөн төрлийн тусгай хамгаалалттай газрыг тодорхойлсон байдаг. Үүнд: Дархан цаазат газар, Байгалийн цогцолборт газар, Байгалийн нөөц газар, Дурсгалт газар багтана.

Төслөөс Гашуун сухайтын хилийн боомт хүрэх зам нь ГБДЦГ-аар дайран өнгөрдөг бөгөөд замын ашиглалт болон менежментэнд Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Тухай Хуулийн заалтуудыг дагаж мөрдөх болно.

Амьтны аймгийн тухай хууль (2000 оны 5-р сарын 5-наас хүчин төгөлдөр болсон)

Энэхүү хуулийн зорилт нь хуурай газар болон усанд амьдардаг амьтдын аймгийг хамгаалах, өсгөн үржүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуулинд ан агнуурт хязгаарлалт тавих, Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны Улаан номонд бүртгэгдсэн ховор болон устаж буй амьтдыг бүртгэх, тэдгээрийн амьдрах орчин ба нүүдлийн замуудыг хамгаалах, дархан цаазат газар байгуулах, төрөл зүйлийг нэмэгдүүлэх болон дахин нутагшуулахтай холбогдсон заалтууд орсон.

Төсөл нь Амьтны Аймгийн Тухай хуулиар хамгаалагдсан ан амьтад оршин амьдардаг бүсэд хэрэгждэг. Тиймээс энэ хуулийн заалтууд нь төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагаанд хэрэглэгдэх бөгөөд Ургамал болон Амьтны аймгийн Менежментийн Төлөвлөгөө нь энэхүү хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд тус дэм болох болно.

Байгалийн ургамлын тухай хууль (1995 оны 6-р сарын 5-наас хүчил төгөлдөр болсон)

Энэ хуулийн зорилт нь ой модноос бусад байгалийн ургамлын зохих ёсны хэрэглээ, хамгаалалт болон нөхөн сэргээлттэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Мөн нэн ховор, ховор болон элбэг ургамлуудын ашиглалтын төлбөрийг тогтоодог Байгалийн Ургамал Ашигласны Төлбөрийн Тухай Хууль байдаг. Төлбөрийг лиценз олгосон сум ба дүүрэгт төлөх ёстой. Төслийн бүсийн ховор ургамлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн *Бүлэг В7: Ургамал-аас үзнэ* үү.

Төсөл нь Байгалийн Ургамлын Тухай Хуулиар хамгаалагдсан ургамлын төрөл ургадаг бүсэд оршдог. Ургамал болон Амьтны аймгийн Менежментийн Төлөвлөгөө нь энэхүү хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд тус дэм болох болно.

Ойн тухай хууль (2007 оны 5-р сарын 17-ноос хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулийн зорилт нь Монгол улсын ой модны хамгаалалт, өмчлөл, тогтвортой хэрэглээ, нөхөн сэргээлт болон нөхөн сэргээлттэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Үүнээс гадна, энэхүү хуулиар төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хайлаас модыг огтлох болон ашиглахыг хориглосон.

Хайлаасны төрлийн мод төсөл болон төслийн бүсийн эргэн тойронд нь ургасан байдаг. Ургамал болон Амьтны аймгийн Менежментийн Төлөвлөгөө нь энэ хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох болно.

2.4.4 Газар, газар ашиглалт ба газар ашиглах эрх цуцлах

Үндсэн хууль

Монгол Улсын Үндсэн Хуулийн дагуу монгол улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар түүнчлэн газрын хэвлий, байгалийн нөөц болон ус зэрэг нь төрийн өмч юм. Үндсэн хуулиар Төрөөс Монгол улсын иргэдэд газар өмчлүүлэх эрхийг олгосон боловч иргэд тухайн газрыг гадаад улсын иргэн,

хуулийн этгээдэд шилжүүлэх эрхгүй байдаг. Газрыг гадаад улсын хуулийн этгээдэд түрээсэлж болдог. **Газрын тухай хууль** (2003 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулиар газрын “эзэмшил” болон “ашиглалтыг” зохицуулдаг. Энэ хуулинд дараахь чухал тодорхойлолтуудыг тусгаж өгчээ:

- “Газар” гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал орон зайн давхаргыг хэлнэ;
- “Газар өмчлөх” гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ;
- “Газрыг эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ;
- “Газар ашиглах” гэж нь хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг хэлнэ;
- “Газар ашиглах эрхийн гэрчилгээ” гэж газрын тухай хуулийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүний газар ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичгийг хэлнэ.

Газрыг зөвшөөрөгдсөн хэрэглээний дагуу хамгаалан, нөхөн сэргээлттэйгээр, үр ашигтайгаар ашиглах ёстой. Хүний эрүүл мэнд, байгаль орчин болон экологийн тэнцвэртэй байдалд, эсхүл улс үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болох бүх үйл ажиллагааг энэ хуулиар хориглосон. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүн нь гэрээний нөхцөл болон хууль тогтоомжид нийцүүлэн, тусгай зориулалтаар, тодорхой хугацаанд газар ашиглагч болж болно.

Газар ашиглалтын төлөвлөлт ба газрыг улсын тусгай хэрэгцээнд авах

Газрын тухай хууль нь газар ашиглалтын төлөвлөлт болон газар ашиглах эрхийг цуцлах үндэслэлийг тусгасан.

Төрийн захиргааны төв байгууллага нь газар ашиглахтай холбогдсон хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх болон газар ашиглалтын ангилалыг засгийн газрын зөвшөөрлийн дагуу тодорхойлох эрхтэй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:

- Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих ба газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;
- Тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснийг үндэслэн газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авах;
- Тусгай хэрэгцээнд авах газрын хэмжээ, зааг болон ашиглах журмыг тогтоох
- Хураан авсан газартай дүйцэхүйц хэмжээний нөхөн олговор олгох талаар шийдвэр гаргах.

Аймаг, нийслэл хот, сум, дүүргийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхүүдийг хэрэгжүүлнэ:

- Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ;
- Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл бэлтгэх;
- Газар эзэмшигч болон тухайн шатны Засаг даргатай тохиролцсоны дагуу газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;
- Газрын төлөв байдлыг илэрхий доройтуулсан бол газрыг албадан чөлөөлүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон доод шатны Засаг даргын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох,.

Сум, дүүргийн Засаг дарга нар нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний дагуу, иргэдэд газар ашиглах болон эзэмших эрх олгох

эрхтэй. Баг, хорооны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ба Засаг дарга нар нь нийтийн эзэмшлийн газрыг зохицуулах ба хамгаалах эрхтэй. Баг болон хорооны Засаг дарга нар нь дээд түвшний удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, газрынтухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Газар эзэмшсэний болон ашигласны төлбөрийн асуудлыг Газрын Төлбөрийн Тухай Хуулиар зохицуулсан (1995 оны 3-р сарын 30) байдаг.

Төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагаа нь энэ хуулиар зохицуулагдах болно. Газрын тухай хуулийн хүрээнд төслийн нөлөөлөлд өртсөн гуравдагч этгээдийн газар ашиглалт болон өмчлөх эрхийг зөв ойлгох нь маш чухал юм.

Газар ашиглалтын уламжлалт зан заншил

Газар ашиглалтын зан заншил нь нутгийн ард иргэдийн дунд уламжлал болон тогтсон дэг жаягт үндэслэн цаг хугацааны явцад боловсрогдон бий болдог. Монгол Улсад уламжлалт газар ашиглалтын зан заншил малчин айл өрхүүдийн дунд бэлчээр хуваарилахад хэрэглэгдсээр ирсэн. Бэлчээрийн эрхийг энэхүү зан заншлаар дараах байдлаар авч үзэж болно:

- Газрыг үе удам дамжин ашигласан;
- Малын өвөлжөө барьсан;
- Тухайн бэлчээр газартай ойрхон худаг эзэмшсэн;
- Бэлчээрийн газартай ойрхон тариалангийн талбай эзэмшсэн.

Нутгийн иргэд бэлчээр ашиглалтын хуваарилалтаа хөршүүдтэйгээ хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр гаргадаг.

Малчдын усан хангамжинд нөлөөлөл үзүүлж буй эсвэл малчдыг нүүлгэн шилжүүлж буй тохиолдлуудад уламжлалт газар эзэмших эрхийнх нь асуудлуудыг зохицуулсан байх ёстой болдог.

Газрын хэвлийн тухай хууль (1989 оны 11-р сарын 29-нөөс хүчин төгөлдөр болсон)

Энэхүү хуулийн зорилт нь тогтвортой хөгжлийн зарчмуудын дагуу газрын хэвлийн ашиглалт болон хамгаалалтын асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Монгол Улсын Үндсэн Хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч юм. Газрын хэвлийг түрээсэлж болох хэдий ч ашиглалтын лиценз олгогдсон тохиолдолд энэ хуулийн 13-р зүйлийн дагуу ашигт малтмалыг олборлоход зориулан газрын хэвлийг ашиглах эрх үүсэх бөгөөд 4-р Бүлэгт дурдсан шимт хөрсийг хамгаалах, уурхайн олборлолтыг үр ашигтайгаар явуулах, гарган авсан хайрга болон бусад материалыг зохих ёсоор ашиглах зэрэг шаардлагыг биелүүлэх ёстой.

Төсөл нь уул уурхайн төсөл учраас энэ хуулийг дагаж мөрдөнө.

2.4.5 Ашигт малтмалын тухай хууль

Уурхайг бүр мөсөн буюу түр зуур хаах талаар хуулийн зохицуулалтыг доорх 2.4.12 хэсэгт авч үзэх болно.

Ашигт малтмалын тухай хууль (2006 оны 7-р сарын 8-наас хүчин төгөлдөр болсон)

Ашигт малтмалын тухай хуулийн зорилт нь ашигт малтмалын хайгуул ба олборлолтын үйл ажиллагааг зохицуулах, уурхайн бүс болон түүний эргэн тойрны газар нутгийг хамгаалахад оршино. Ашигт малтмалыг 'геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлал' гэж тодорхойлсон байдаг ба үүнд газрын тос болон байгалийн хий багтдаггүй.

Ашигт малтмалын нөөц нь төрийн өмч юм. Төр нь хайгуул болон олборлолт хийх эрхийг олгох бөгөөд нийгэм, эдийн засгийн хөгжилд томоохон нөлөө үзүүлэхүйц ордуудыг 'стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд' гэх ба стратегийн ордод лиценз эзэмшигчээс оруулж байгаа нийт хөрөнгө оруулалтын 34 хүртэлх хувийг төр эзэмшинэ.

Ашигт малтмалын хайгуул ба олборлолтын лицензийг Монгол улсад татвар төлөгч Монгол Улсын хуулийн этгээдэд олгож болно. Хуулийн этгээдэд ашигт малтмалын зөвхөн нэг лицензийг өгдөг хэдий ч, хуулийн этгээдийн эзэмшиж болох хайгуулын лицензийн тоонд ямар нэгэн хязгаарлалтыг тавиагүй билээ.

Ашиглалтын өмнөх үйл ажиллагааг хайгуулын лиценз эзэмшигч болон холбогдох төрийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан ашиглалтын өмнөх гэрээгээр зохицуулна. Ашиглалт өмнөх үйл ажиллагаа гэдэг нь уурхайн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулагдаж, техник-эдийн засгийн үндэслэл хийгдэн, уурхайн бүтээн байгуулалт болон үйлдвэрлэл эхлэх хайгуулын ажлын дараах үе юм.

Оюу Толгойн төсөл гэх мэт стратегийн орд газрын хувьд ашигт малтмалын лицензийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 жилийн хугацаагаар 2 удаа сунгаж болно. Ашигт малтмалын лицензийн хүрээнд дараах эрхүүд олгогддог. Үүнд:

- Тухайн уурхайн талбайд олборлолт болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулах зорилгоор ашиглах
- Энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөл, эзэмшилд байгаа газарт түүний өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрсний дагуу нэвтрэх, дайран өнгөрөх;
- Холбогдох хууль тогтоомжийн дагуу ус ашиглах ;
- Ашигт малтмалын бүтээгдэхүүнийг олон улсын зах зээл дээр борлуулах;
- Ашигт малтмалын ашиглалтын лицензийг шилжүүлэх, уурхайн талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаан өгөх.

Ашигт малтмалын лиценз эзэмшигчид дараах үүргийг хүлээнэ:

- Уурхайн талбайн хил хязгаарыг тогтоох;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг мөрдөх;
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг (БОХТ) ашиглалтын лиценз авснаас хойш 30 хоногт боловсруулах

Холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх. Хэрвээ лиценз эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлээгүй бол, уг байршуулсан мөнгийг сум, дүүрэг нь дээрхи зорилгоор ашиглаж болно. Хэрвээ лиценз эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах үүргээ эсвэл уурхайн үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагаатай холбоотой хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ зөрчвөл, улсын байцаагч уурхайн үйл ажиллагааг 2 сар хүртэлх хугацаагаар түр зогсоож болно. Хэрвээ энэ хугацааны туршид тухайн байдал засрахгүй бол, хуульд заасны дагуу лицензийг цуцлах арга хэмжээ авах ба энэ тохиолдолд лиценз эзэмшигч нь шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Хуулийн 39-р Зүйлд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчин хамгаалах үүргүүдийг тусгасан байдаг. Үүнд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)-г болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулах багтана. БОХТ-нд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээлт, хөрсөөр хучих, ургамалжуулах зэрэг арга хэмжээнүүдийг багтаах шаардлагатай байдаг. Улмаар уурхай хаагдсаны дараа уг газрыг дахин ашиглах боломжтой болох юм.

Дээр дурдсанчилан, ашигт малтмалын тухай хуулийн дагуу, ашиглалтын лиценз эзэмшигч нь жил бүр тусгай дансанд тухайн жилийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх үүрэгтэй. Уг шилжүүлсэн байгаль орчныг хамгаалах татварын сан нь ашиглалтын лиценз эзэмшигч байгаль орчны нөхөн сэргээлт бүрэн хийгдээгүй тохиолдолд зарцуулагдах болно. Засгийн газар дараа нь тухайн санг байгаль орчныг нөхөн сэргээх ажилд ашиглах бөгөөд нэмэлт шаардагдах хөрөнгийг лиценз эзэмшигч хариуцна

Оюу Толгой төсөл нь ашиглалтын лицензтэй.

Оюу Толгой төсөл нь энэ хуулиар зохицуулагддаг. Байгаль орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэхийн тулд энэ хуулийн шаардлагуудыг дагаж мөрдөх ёстой бөгөөд ашигт малтмалын лиценз эзэмшигчид нь Монгол улсын байгаль орчны тухай хууль тогтоомжийн заалтуудыг биелүүлэх үүрэгтэй.

2.4.6 Усны тухай хууль

Усны тухай хууль (1995 оны 6-р сарын 5-наас хүчин төгөлдөр болсон)

Энэ хууль нь усны нөөцийг зохих ёсоор ашиглах, хамгаалах болон нөхөн сэргээх тухай заалтуудыг багтаасан. Уг хуулиар усны нөөцийн бүртгэлийг ("Усны Нөөц") хөтлөх журмыг тогтоосон ба ийм нөөцөөс тодорхой хугацаанд 'усны экологийн тэнцвэртэй байдлыг' алдагдуулалгүйгээр авч ашиглаж болох усны дээд хэмжээг ("боломжит нөөц") тогтоож өгсөн байдаг.

Энэ хууль нь зөвхөн төслийн усны хэрэглээг зохицуулах болно. Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө нь энэ хуулийн хэрэгжилтийг хөнгөвчлөх болно.

Усны хэрэглээний уламжлалт зан заншил

Энэ зан заншил нь ард иргэдийн дунд уламжлал болон тогтсон дэг жаягт үндэслэн цаг хугацааны явцад боловсрогдон бий болсон. Монгол улсад хөрш саахалт айлууд болон хамтран эзэмшигчидтэйгээ усаа хэрхэн ашиглах талаар хэлэлцэн тохиролцдог. Тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд малчид сумын буюу багийнхаа засаг захиргаанд ханддаг.

Малчдыг нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд ус ашиглах уламжлалын асуудлыг анхаарч зохицуулах ёстой.

2.4.7 Агаарын бохирдлын тухай хууль

Агаарын тухай хууль 1995 (1995 оны 6-р сарын 5-наас хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулиар суурин эх үүсвэрүүдээс агаар мандалд ялгарах хаягдлын хэмжээг бууруулах үүднээс хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэх эрхийг Засгийн газарт олгосон. Түүнчлэн энэхүү хуулинд, бүхий л эх үүсвэрүүдээс агаарт ялгарах хаягдлын стандарт дээд хэмжээг тогтоосон заалтуудыг багтаасан. Суурин эх үүсвэрээс ялгарах хаягдлын хэмжээ тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд байгаль орчны улсын байцаагч тухайн эх үүсвэрийн үйл ажиллагааг хааж болно.

Олон улсын стандартуудын дагуу шинээр баригдах ба өргөтгөлийн байгууламжуудад агаарт ялгаруулах бохирдлын хяналт шалгалт ба хүлэмжийн хийг багасгах технологи зэрэг бохирдолтыг багасгах технологи хэрэгжүүлэхийг шаарддаг. Мөн хуулиар агаар мандалд ялгаруулж буй хаягдлын хэмжээнээс шалтгаалан төлбөрийн тогтолцоог санал болгосон. Агаарын төлбөрийн тухай хуулиар тэрхүү төлбөрийг илүү нарийвчлан тодорхойлдог байдаг.

Энэ хууль нь төслийн үйл ажиллагаанаас агаарт ялгарах хаягдлын хэмжээг зохицуулах болно. Агаар мандлын бохирдлын Менежментийн Төлөвлөгөө нь энэ хуулийг урт хугацааны туршид дагаж мөрдөх үйл ажиллагааг хангах болно.

2.4.8 Хог хаягдал болон аюултай бодисууд

Ахуйн болон Үйлдвэрлэлийн Хог Хаягдалын тухай Хууль (2004 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулиар ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах болон хогийн цэгт булах зэрэг үйл ажиллагааг зохицуулдаг. Хог хаягдлыг дарж, булж устгах цэг (ландфил) үүсгэх зөвшөөрлийг сум буюу дүүргийн Засаг дарга нар олгодог ба их хэмжээний хог хаягдал гаргадаг үйлдвэрлэл эрхэлдэг байгуулагууд нь гаргасан хог хаягдлаа тогтоосон стандартын дагуу заагдсан газарт хог хаягдлыг дарж, булж устгах цэг (ландфил) үүсгэн хаягдлаа булах ёстой.

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн ба үйлдвэрийн хог хаягдал үүсэх ба Төслийн Хаягдлын менежментийн төвд ландфил байгуулах болно.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2006 оны 5-р сарын 25-наас хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулиар химийн хорт бодисуудын импорт, экспорт, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт болон хяналтын үйл ажиллагааг зохицуулдаг. Мөн энэ хуулиар хорт болон аюултай бодисуудын хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулахаас сэргийлэх арга хэмжээнүүдийг ноогдуулж өгсөн байдаг.

Төслийн бүсэд химийн бодисууд ашиглагдах ба төслийн бүсээс дотогш, гадагш болон бүс дотор тээвэрлэгдэх болно. Аюултай материалуудын менежментийн төлөвлөгөө нь энэ хуулийн заалтыг биелүүлэхэд чиглэнэ.

2.4.9 Соёлын өв

Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2001 оны 6-р сарын 8-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон)

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зорилт нь биет болон биет бус соёлын өвийг эрэн сурвалжлан цуглуулах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж, хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших болон ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Төслийн бүсэд биет соёлын өв байгаа эсэхийг тогтоох өргөн хүрээний судалгааны ажлууд хийсэн. Биет бус соёлын өвийн суурь судалгааны үнэлгээг мөн хийсэн бөгөөд Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө нь энэ хуулийг дагаж мөрдөн, биелүүлэх нөхцөлийг хангах болно.

2.4.10 Байгаль орчны төлбөр

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах ба байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хууль (2000 оны 10-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон)

Монгол улсын хуулийн дагуу байгалийн нөөц ашигласны төлбөр төлдөг. Ус, рашаан, мод болон түлээний мод, газар, ан амьтад болон байгалийн ургамлын аймаг зэрэг байгалийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тусгай хуулиудаар тогтоож өгсөн байдаг. Уг хууль нь энэ төлбөрөөс байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулагдах хувь хэмжээг тогтоож өгөх зорилготой.

Энэхүү хуулиар Засгийн газар нь төслөөс төлж байгаа төлбөрийн хэдэн хувийг нь байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөцийг нөхөн сэргээх ажилд зарцуулах ёстойг тодорхойлж өгнө. Байгаль орчны төлбөрийг цаг тухайд нь төлөх явдлыг хангах үйл ажиллагааны журмууд батлагдан хэрэгжиж байгаа.

2.4.11 Эрүүл мэнд ба аюулгүй байдал

Химийн бодисуудыг хадгалах, ашиглах ба тэдгээртэй харьцах тухай хуулиуд нь энэ бүлгийн 2.4.8.-д дурдагдсан болно.

Ариун цэврийн тухай Хууль (1998 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулийн зорилт нь иргэний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийг баталгаажуулах ба үүнтэй холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эдлэх эрх ба хүлээх үүргүүдийг тодорхойлоход оршино. Энэ хууль нь холбогдох дүрэм журмын дагуу дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагыг тавьдаг:

- Ундны болон ахуйн усан хангамж;
- Агаарын чанар, түүний дотор тоос, утаа болон бохирдолт;
- Хөрсний эрүүл ахуй, хог хаягдлыг устгах, бохир усны байгууламжууд, усны цооногууд болон бие засах газрууд;
- Эмнэлэгийн хог хаягдал, цацраг идэвхит болон химийн хортой бодисуудын устгал;
- Орон сууц болон нийтийн хэрэглээний байгууламжуудыг барьж байгуулах;
- Химийн хорт бодис болон ионжсан туяаны хэрэглээ;
- Байгаль орчинд дуу чимээ ихтэй эсвэл доргио чичиргээ, цахилгаан соронзон орон юмуу радио долгион ялгаруулах үйл ажиллагаа;
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон хэрэглээ; ба
- Бүтээгдэхүүн болон технологийн импорт.

Энэ хуулийн дагуу аж ахуйн байгууллага нь дараах үүргүүдийг хүлээнэ:

- Өөрийн эрхэлдэг бизнесийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулах, түүний дотор ажилчидаа сургах; ба

- Хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд хор хохирол учруулж болзошгүй ямар нэгэн нөхцлийн талаар хяналт шалгалтын мэргэжлийн байгууллагад мэдэгдэх.
- Төслийн бүх үйл ажиллагаа нь Монгол улсын Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаарх хуулиудаар зохицуулагдах болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө зэрэг нь энэ хуулийн хэрэгжилтийг хангах баталгаа болно.

Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль

Энэ хуулийг цацраг идэвхийн эх үүсвэр гэж тооцогдох аливаа материал юмуу тоног төхөөрөмжийг ашиглахад мөрдөнө. Энэ төрлийн тоног төхөөрөмж эсвэл материалыг импортлохоосоо өмнө холбогдох байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан байх ёстой. Эдгээр зүйлсийг холбогдох байгууллагын тодорхойлсон дүрэм журмын дагуу хадгалах бөгөөд тэдгээрийн хяналтан дор устгах ёстой.

Төслийн бүсэд буй тоног төхөөрөмжүүдийн ашиглалт нь энэ хуулиар зохицуулагдах болно. Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө нь энэхүү хуулийг дагаж мөрдөхөд тус болох болно.

Уурхайн үйл ажиллагааг түр хугацаагаар буюу бүрмөсөн хаах талаарх журам (2003 оны 8-р сарын 21-нээс хүчин төгөлдөр болсон)

Энэ журамд уурхайн үйл ажиллагааг түр хугацаагаар буюу бүрмөсөн хаах тохиолдолд авах шаардлагатай засан сайжруулах арга хэмжээнүүдийн талаар заасан. Эдгээр журмуудын зорилго нь уурхайн үйл ажиллагааг хаасан тохиолдолд хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хор хохирол учруулахаас сэргийлэхэд оршино. Түр хаах тохиолдол нь хүчин төгөлдөр лицензтэй уурхайд дараахь нөхцөл байдал үүссэн үед гарч болно: уурхайн геологи эсвэл гадаргын усанд өөрчлөлт гарсан үед; техник, эдийн засгийн өөрчлөлтийн үед; бусад тогтоогдоогүй тохиолдолд.

Уурхайн үйл ажиллагааг дараах тохиолдлуудад бүрмөсөн хаадаг: уурхайн батлагдсан нөөц дууссан; ашигт малтмалыг нь Улсын Ашигт малтмалын Бүртгэлээс хассан; нөөцийг ихэсгэх ямар ч боломж байхгүй тохиолдол.

Журамд заанаар уурхайг хаах тохиолдолд төслийн удирдлагууд дараах арга хэмжээг дэс дарааллан хэрэгжүүлнэ. Үүнд: .

- Лиценз эзэмшигч нь уурхайн үйл ажиллагааг бүрмөсөн хааж байгааг Улсын Мэргэжлийн Хяналтын Газарт (УМХГ) мэдэгдэх;
- Лиценз эзэмшигч нь Уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулан УМХГ-аар батлуулах; ба
- Лиценз эзэмшигч нь хаягдал чулуулгийн овоолгын талаарх нарийвчилсан мэдээллүүд; байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийн ажлын нарийвчилсан мэдээллүүд; нөхөн сэргээлтийн ажлын нарийвчилсан мэдээллүүд; уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр бий болсон аюултай байж болзошгүй бүсүүдийг харуулсан газрын зураг зэрэг нэмэлт баримт бичгийг бүрдүүлнэ

Журамд нь гүний уурхайн үйл ажиллагааг түр хугацаагаар буюу бүрмөсөн хаах тохиолдолд авч хэрэгжүүлэх ёстой нарийвчилсан үйл ажиллагаануудыг зааж өгсөн байдаг.

Төслийн бүсэд уурхайн үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн хаах ажлууд нь энэ журмын дагуу зохицуулагдах болно. Уурхайн хаалтын төлөвлөгөө нь энэ журмыг хэрэгжүүлэх нөхцлийг хангах болно.

2.4.12 Хөдөлмөрийн тухай хууль

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээрх хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны нөхцөл болон хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан ба ажил олгогчийн нийтлэг эрх, үүргийг тодорхойлж, хөдөлмөрийн харилцаан дахь хүйсийн эрх тэгш байдлыг хангахад оршино,

Энэ хуулийн дагуу ажилтан нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хууль тогтоомжид нийцсэн ажлын орчин нөхцөлөөр хангагдсан байх; гүйцэтгэсэн ажилдаа тохирсон цалин хөлс авах; амралт эдлэх; өөрийнхөө эрхийг болон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор төлөөллийн байгууллага байгуулах буюу хамтын гэрээгээр дамжуулан бусад ажилчидтай чөлөөтэй эвлэлдэн нэгдэх; тодорхой нөхцөл байдалд ажил хаях; тэтгэвэр тэтгэмж авах, нийгмийн даатгалд хамрагдах, ажил үүргээ гүйцэтгэх явцад нас барсан тохиолдолд гэр бүл нь тэтгэмж авах болон хөдөлмөрийн ба хамтын гэрээнд тусгагдсан бусад тэтгэмжүүдийг авах эрхтэй.

Ажлын байранд хүмүүсийг яс үндэс, арьс өнгө, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө мөнгөний хэмжээ, шашин шүтлэг, эсвэл үзэл бодлын үүднээс ялгаварлан гадуурхахыг хориглодог. ба Түүнчлэн эмэгтэйчүүдэд зарим төрлийн ажил хийхийг хориглосон байдаг¹. Хүүхэдтэй эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглох ба эмэгтэй ажилтан жирэмсний амралт авах эрхтэй байдаг. Гурваас доош насны хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдээ асран халамжлах зорилгоор чөлөө авч болох бөгөөд ажил олгогч нь тэднийг эргэн ажилдаа орох хүртэл ажлын байрыг нь хадгалах үүрэгтэй.

Хамтын хэлэлцээр нь мэргэжлийн буюу эдийн засгийн салбараар мөн түүнчлэн бүс нутаг, сум, аймаг, дүүрэг эсвэл нийслэл хотын түвшинд хийгдэж болно. Ийм хамтын хэлэлцээрүүд нь холбогдох байгууллагад бүртгэгдсэн байх ёстой. Хөдөлмөрийн арбитрын шүүхээр хамтын хөдөлмөрийн маргааныг шийддэг бөгөөд хувь хүнтэй холбоотой хөдөлмөрийн маргааныг шүүх эсвэл маргаан таслах комисс шийддэг.

Хөдөлмөрийн хууль нь төслийн ажилтнуудын ажил эрхлэлтийн харилцааг зохицуулах бөгөөд гэрээний нөхцөл, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, хүйсийн тэгш байдал болон эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд мөн хэрэглэгдэнэ. Энэ хууль нь хөдөлмөрийн гэрээ болон менежментийн хэд хэдэн төлөвлөгөөгөөр хэрэгжих болно.

2.5 МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТУУД

Оюу Толгой төслийн байгаль орчны чанар болон эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартуудыг доорх Хүснэгт 2.1-д нэгтгэн үзүүлэв. Эдгээр стандартууд нь Монгол улсын хуулийн шаардлагатай нийцэн хэрэгждэг ба эдгээр журмуудад тусгагдсан гол гол стандартуудын талаар БОННБУ-ий суурь бүлгүүдэд илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.

Хүснэгт 2.1: Оюу Толгой төслийн барилгын болон үйлдвэрлэлийн үе шатны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд

№	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд
1	MNS (ISO) 5667-1:2002 Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 1. Дээжлэлтийн хөтөлбөр боловсруулах удирдамж.
2	MNS 900:2005 Байгаль орчин. Хүний эрүүл мэндийн хамгаалалт. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлагууд болон чанарын хяналт.
3	MNS (ISO) 5667-2:2001 Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 2. Дээжлэлтийн аргачлалын удирдамж.
4	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 3. Дээж бэлтгэх ба хадгалах зөвлөмж.
5	MNS (ISO) 5667-4:2001 Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 4. Байгалийн ба хиймэл нуурын усны дээжлэлтийн удирдамж.
6	MNS (ISO) 5667-10:2001 Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 10. Бохир усны дээжлэлтийн удирдамж.
7	MNS (ISO) 5667-11:2000 Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 11. Гүний усны дээжлэлтийн удирдамж.
8	MNS (ISO) 5667-13:2001 Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 13. Бохир ус ба цэвэрлэх байгууламжийн лагийн дээжлэлтийн удирдамж.

¹ Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам эмэгтэйчүүдийн эрхлэхийг хориглосон ажлын байрны шинэчилсэн жагсаалтын төслийг боловсруулж байна.

№	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд
9	MNS (ISO) 11083:2001 Байгаль орчин. Усны чанар. спектрометрийн аргаар (1.5-дифенилкарбазид) хром (VI) тодорхойлох.
10	MNS 5032:2001 Усны чанар. Рентген флюоресценц аргаар усан дахь хүнд металлын агуулгыг тодорхойлох.
11	MNS (ISO) 11923:2001 Усны чанар. Шилэн шүүлтүүрээр (мяндсан шүүлтүүр) усан дахь умбуур бодис тодорхойлох.
12	MNS 4943:2000 Усны чанар. Бохир ус.
13	MNS (ISO) 4889:1999 Усны чанар. Цахилгаан дамжуулах чанарыг тодорхойлох.
14	MNS 4586:1998 Усны хүрээлэн буй орчны чанар. Ерөнхий шаардлагууд.
15	MNS 4420:1997 Ундны ус. Усан дахь мөнгөн усны агуулгыг тодорхойлох. Атом шингээлтийн арга.
16	MNS 4430:2005 Ундны ус. Усан дахь төмрийн агуулгыг тодорхойлох.
17	MNS 2573:1978 Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Усны чанарын үзүүлэлтүүд.
18	MNS 4345:1996 Үйлдвэрлэлийн ус. Химийн шинжилгээний цэвэршүүсэн ус бэлтгэх арга.
19	MNS 4341:1996 Үйлдвэрлэлийн ус. Усан дахь магнийн агуулгыг тодорхойлох
20	MNS 4348:1996 Үйлдвэрлэлийн ус. Усан дахь зэсийн агуулгыг тодорхойлох.
21	MNS 4431:2005 Үйлдвэрлэлийн ус. Усан дахь азотын агуулгыг тодорхойлох
22	MNS 4288:1995 Бохир ус цэвэршүүлэх байгууламж байгуулах газрын сонголтонд тавигдах ерөнхий шаардлагууд, цэвэршүүлэх технологиуд ба үр ашигтай байдал.
23	MNS 4217:1994 Ундны ус. Усан дахь нийт азотын агуулгыг тодорхойлох.
24	MNS 0899:1992 Усан хангамжийн эх үүсвэрийн сонголтонд тавигдах шаардлагууд, дүрэм журмууд ба эрүүл ахуйн шаардлагууд.
25	MNS 4047:88 Байгаль орчны хамгаалалт. Усан мандал. Гадаргын усны чанарын хяналт шалгалтын журам.
26	MNS 3935:1986 Ундны ус. Усыг газар дээр нь шинжлэх ерөнхий шаардлагууд.
27	MNS 3936:1986 Ундны ус. Усыг газар дээр нь шинжлэх аргууд.
28	MNS 3900:1986 Ундны ус. Усны амт, өнгө, үнэр ба булингарыг тодорхойлох.
29	MNS 3597:1983 Гадаргуун болон гүний усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд.
30	MNS 3532:1983 Гадаргуун ус. Усан дахь цагаан тугалганы агуулгыг тодорхойлох.
31	MNS 3342:1982 Гүний усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд.
32	MNS 6148:2010 Усны чанар. Гүний усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх агууламж.
33	MNS 0017-1-5-15:1980 Байгаль орчны хамгаалалт. Усан мандал. Усан дахь нефтийн бүтээгдэхүүнийг тодорхойлох.
34	MNS 0017-1-1-10:1979 Ус ашиглалт ба хамгаалалт. Нэр томъёо, тодорхойлолт.
35	MNS 0017-1-1-14:1980 Усан мандал. Ус ашиглалтын ангилал. Ерөнхий шаардлагууд.
36	MNS 4423:1997. Ундны ус. Хуурай үлдэгдлийг тодорхойлох арга.
37	MNS 2570:1978 Усны ариун чанарыг тодорхойлох арга.
38	MNS 4079:1988 Усны чанарын нэр томъёо ба тодорхойлолт.
39	MNS (ISO) 7887:2000 Усны чанар. Усны өнгийг тодорхойлж шалгах арга.

№	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд
40	MNS 5790:2007 Усны чанар. Усан дахь марганцийн агуулгыг тодорхойлох.
41	MNS (ISO) 4817:1999 Усны чанар. Усан дахь аммонийн агуулгыг тодорхойлох.
42	MNS (ISO) 7980:2003 Усны чанар. Усан дахь кальци, магнийн агуулгыг атом шингээлтийн аргаар тодорхойлох.
43	MNS (ISO) 5814:2005. Усны чанар. Усан дахь уусаагүй хүчилтөрөгчийн хэмжээг тодорхойлох. Цахилгаан химийн арга.
44	MNS (ISO) 6060:2001 Усны чанар. Усан дахь химийн үчилтөрөгчийн хэрэгцээг тодорхойлох.
45	MNS (ISO) 9280:2001 Усны чанар. Барийн хлоридын жингийн аргаар усан дахь сульфат тодорхойлох..
46	MNS (ISO) 10523:2001 Усны чанар. Рн тодорхойлох.
47	MNS 0017-2-3-16:1988 Байгаль орчны хамгаалалт. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарын хяналт шалгалтын журам.
48	MNS 3384:1982 Агаар мандал. Дээжлэлтэнд тавигдах ерөнхий шаардлагууд.
49	MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо, тодорхойлолт.
50	MNS 4990:2000. Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлагууд.
51	MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх агууламж.
52	MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Ерөнхий оршил. Үг хэллэг.
53	MNS 5365:2004. Агаарын чанарын ерөнхий асуудлууд. Нарийн ширхэгтэй тоосонцорыг тодорхойлох арга.
54	MNS 4219:1994 Байгаль орчны хамгаалалт. Аж ахуйн нэгжүүдэд олгох экологийн гэрчилгээ. Гол журмууд.
55	MNS 4219:2002 Агаарын чанар. Орчны агаар дахь хүхрийн агууламжийг тодорхойлох.
56	MNS 5914:2008 Байгаль орчин. Газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт.
57	MNS 5915:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын ангилал.
58	MNS 5916:2008 Байгаль орчин. Үржил шимт хөрс хуулалт ба газар шорооны ажлын явцын түр хадгалалтанд тавигдах шаардлагууд.
59	MNS 5917:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлагууд.
60	MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдрэлд орсон газрын ургамлын бүрхүүлийн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлагууд.
61	MNS 4920:2000 Байгаль орчин. Эвдрэлд орсон газрын налуу. Техникийн шаардлагууд.
62	MNS 3298:1991 Хөрс. Дээжлэлтийн ерөнхий шаардлагууд.
63	MNS 3297:1991 Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ.
64	MNS 0017-0-0-06:1979 Байгаль орчны хамгаалалтын стандарт тогтолцоо.
65	MNS 3473:1983 Байгаль орчин. Газар. Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт.
66	MNS 5002:2000 Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа. Дуу чимээний стандартын ерөнхий шаардлагууд ба аюулгүй ажлын дүрэм журмууд.
67	MNS 5003:2000 Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа. Дуу чимээний хэмжилтэнд тавигдах ерөнхий шаардлагууд.
68	MNS 12.1.009:1985 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Дуу чимээ. Орон сууц ба иргэний байгууламжуудын

№	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд
	дуу чимээний зөвшөөрөгдөх түвшин.
69	MNS 12.1.06:1988 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт тогтолцоо. Хэт их дуу чимээ. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагууд.
70	MNS 12.4.005:1985 Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа. Дуу чимээнээс хамгаалах хэрэгсэл ба аргууд. Ангилал.
71	MNS 12.1.017:1988 Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа. Хэт их дуу чимээ. Ажлын байрны дуу чимээний нөлөөллийг хэмжих арга.
72	MNS 5666:2006 Усны биологийн шинж чанарын үнэлгээ. Бохир ус цэвэрлэх байгууламжийн идэвхт лагийг тодорхойлох арга.
73	MNS 5668:2006 Усны биологийн шинж чанарын үнэлгээ. Бохир усны микробиологийн шинжилгээний арга.
74	MNS 4585: Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлагууд.
75	MNS-3384:82 Агаар мандал. Дээжлэлтийн ерөнхий шаардлагууд.
76	MNS-4048:88 Агаар мандал. Тоосны агууламжийг тодорхойлох жингийн арга.

Тэмдэглэл: хөх = усны чанарын стандартууд; ногоон = газар хамгаалалт, хөрс ба экологийн стандартууд; саарал = агаарын чанарын стандартууд; улбар шар = хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагааны стандартууд.

Монгол улсын Стандарчилал хэмжил зүйн үндэсний төв (МСХҮТ) нь монгол улсын стандартуудын боловруулалт ба зөвшилцлийг хариуцдаг юм. Үндэсний стандартуудыг бэлтгэх, хэрэгжүүлэх болон сурталчлах ажлуудыг 2003 онд батлагдсан Монгол Улсын Стандарчилал, тохирлын үнэлгээний тухай хуулинд зааж өгсөн байдаг.

Стандартуудыг ISO стандарттай нийцүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд ISO стандарттай нийцсэн стандартуудыг дээрх хүснэгтэнд үзүүлсэн болно.

2.6 ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭРҮҮД

Олон улсын гэрээгээр улс орнууд тухайн гэрээнд заагдсаны дагуу тодорхой үйлдэл, үйл ажиллагааг явуулах эсвэл үйл ажиллагаанаас татгалзах үүргийг хүлээдэг. Олон улсын гэрээ хэлэлцээрт заагдсан үүргийг дотооддоо хэрэгжүүлэх тохиолдолд, засгийн газар нь олон улсын гэрээний нөхцөлүүдийг хэрэгжүүлэх үндэсний хуулиудыг батлан гаргах ёстой. Монгол улсын Засгийн газраас олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан тодорхой хуулиудыг олон нийтэд таниулдаг. Харин “Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн заалттай үндэсний хууль тогтоомж зөрчилдвөл олон улсын гэрээ хэлэлцээрийн заалтуудыг мөрдөнө” гэсэн зарчмыг хуулиндаа тусгаж өгсөн. Иймд, төслийн хүрээнд үйлчлэх Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийг мэддэг байх хэрэгтэй. Төсөлд хамааралтай олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг доор товчлон дурдав.

2.6.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

НҮБ-ын европ дахь Эдийн засгийн комиссын (НҮБЕЭЗК) хилийн чанадад хийгдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай конвенци ('Espoo Конвенци') (1997 оны 9-р сарын 10-наас хүчин төгөлдөр болсон, Монгол улс соёрхон батлаагүй байгаа)

Espoo Конвенци нь оролцогч талуудад үйл ажиллагааныхаа төлөвлөлтийн эхний үе шатанд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх үүргийг хүлээлгэдэг. Мөн болзошгүй хил дамнансан байгаль орчны сөрөг нөлөөлөл бүхий томоохон төслүүдийн талаар бие биедээ мэдэгдэж зөвлөлдөж байхыг гишүүн орнуудад ерөнхий үүрэг болгосон байдаг.

НҮБЕЭЗК (Нэгдсэн Үндэсний Байгууллагын Европ дахь Эдийн Засгийн Комисс) нь НҮБ-ын бүс нутгийн хэмжээний 5 комиссын нэг нь юм. Түүний гол зорилго нь нэгдсэн Европын эдийн засгийн интеграциалд тус дэм болох явдал юм. Үүний тулд, НҮБЕЭЗК нь Европын Холбооны (ЕХ) гишүүн орнууд, ЕХ-нд элсээгүй баруун, зүүн болон зүүн-өмнөд Европын улсууд болон Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн болон Хойд Америк зэрэгт байрлах 56 улс орныг нэгтгэдэг. Монгол улс нь

гишүүн улс биш ба дээр дурьдагдсан конвенц болон протоколд оролцогч тал биш юм. Хэдий тийм ч Espoo Конвенци болон түүний Протокол нь төсөлд хамааралтай юм учир нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Гүйцэтгэлийн Шаардлага нь үйлчлүүлэгчдээсээ оролцогч талуудтайгаа Espoo конвенцийн үзэл санаа, зорилго ба эцсийн зорилготой нийцсэн байдлаар хамтарч ажиллахыг шаарддаг. Espoo конвенци нь биологийн төрөл зүйлүүдийг хадгалах болон байгалийн амьд нөөцийн тогтвортой менежмент хийх чиглэлүүдэд анхаарлаа хандуулсан ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6-н хүрээнд төсөлд хамааралтай байдаг юм.

НҮБЕЭЗК-ын Киевийн Espoo конвенцийн SEA протокол (2010 оны 7-р сарын 11-нээс хүчин төгөлдөр болсон, Монгол улсад батлагдаагүй)

Энэ протоколын зорилго нь засгийн газруудын байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр гаргаж буй стратегийн шийдвэрүүдийг мэдээлэхдээ байгаль орчны шийдлүүдийг нэгдсэн байдлаар авч үзэх явдлыг баталгаажуулахад оршино. Энэ протокол нь мөн засгийн газрын шийдвэр гаргах явцад олон нийтийг өргөн хүрээнд хамруулан оролцуулахыг санал болгодог.

2.6.2 Ургамал, амьтны аймгийн хамгаалалт

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц ('ЗАНЗХК') (1999 оны 6-р сарын 24-нөөс Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Энэ Конвенцийн зорилго нь хуурай газрын, усны болон нүүдэлчин шувуудын төрөл зүйлүүдийг тархсан хүрээтэй нь хамгаалахад оршино. ЗАНЗХК -ийн хүрээнд хэд хэдэн гэрээ хэлэлцээр болон харилцан ойлголцлын санамж бичгийг гаргасан бөгөөд тэдгээр нь устан алга болох аюулд өртөөд буй төрөл зүйлүүдэд чиглэгдсэн. Монгол улс нь ЗАНЗХК -д нэгдэн орсон бөгөөд түүний дагуу холбогдох гэрээ хэлэлцээрүүд болон санамж бичгүүдэд нь гарын үсэг зурсан.

Африк болон евроазид агнуурын нүүдлийн шувуудыг хамгаалах тухай харилцан ойлгоцлын санамж бичиг (2008 оны 10-р сарын 22-нд Монгол улс гарын үсэг зурсан)

Энэхүү санамж бичгийн гол зорилго нь агнуурын нүүдэлчин шувуудын тархсан хүрээ, тоо сүргийн өөрчлөлтийн динамик ба амьдрах орчинд нь тааламжтай нөхцөл байдал бүрдүүлэн хамгаалах явдал юм. Энэ зорилгод хүрэхийн тулд санамж бичигт нэлээд хэдэн арга хэмжээг төлөвлөж өгсөн ба үүнд: холбогдох үндэсний хуулиудыг батлан олон нийтэд зарлах, эдгээр төрлийн шувуудын оршин байх газруудыг тодорхойлон хамгаалах болон тоо толгойг нь өсгөх зэрэг багтана.

Сибирийн тогорууг хамгаалах арга хэмжээг авах талаарх харилцан ойлгоцлын санамж бичиг (2004 оны 4-р сарын 29-нд Монгол улс гарын үсэг зурсан)

Сибирийн тогорууг нүүдэллэх үед нь агнаснаас болон өвөлжих газруудын амьдрах орчин нь доройтсоноос устах аюул учраад байгаа юм. Энэхүү санамж бичгийн зорилго нь Сибирийн тогорууны үлдсэн тоо толгойн хорогдлыг багасгах, тэдгээрийн амьдрах орчинг нь сайжруулах, хамгаалах болон дамжин өнгөрдөг улс орон болон холбогдох агентлагуудтай шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хамтран ажиллах зэрэгт оршино.

Бөхөн гөрөөсийг хамгаалах тухай харилцан ойлгоцлын санамж бичиг (2010 оны 9-р сарын 10-нд Монгол улс гарын үсэг зурсан)

Энэхүү санамж бичгийн зорилго нь бөхөн гөрөөс дамжин нүүдэллэдэг бүхий л улс орнууд болон бөхөн гөрөөсний эвэр зэрэг бүтээгдэхүүнийг импортолдог улс орнуудад тэдгээрийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх зааварчилгаа болж чадахуйц замын зураглал гарган өгөх явдал юм. Үүний тулд нэлээд хэдэн арга хэмжээг авах ёстой ба түүний дотор сүргийн тоо толгойн хяналт шалгалтыг сайжруулах, хулгайн ангийн хяналт, мэдээллийг сайжруулах болон тэжээвэр байдлаар өсгөн үржүүлэх зэрэг багтана.

Олон улсын ач холбогдол бүхий намгархаг газар, ялангуяа усны шувуудын амьдрах орчны талаарх Конвенци (1998 оны 4-р сарын 8-наас хүчин төгөлдөр болсон)

Энэхүү Конвенци нь олон улсын ач холбогдол бүхий намгархаг газрыг хамгаалах болон тогтвортой хөгжлийн үүднээс ашиглах зэрэг чиглэлээр үндэсний үйл ажиллагааны болон олон улсын хамтын ажиллагааны цар хүрээг тогтоож өгдөг.

Ховордсон амьтан ба ургамлын гадаад худалдааг зохицуулах тухай (1995 оны 5-р сарын 1-нээс Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Ховордсон амьтан болон ургамлын олон улсын зах зээл дээрх худалдааг зохицуулах конвенц нь зэрлэг амьтад ба ургамлын зүйлийн олон улсын худалдаа нь тэдгээрийг мөхөлд хүргэхгүйгээр явагдаж байгааг баталгаажуулах зорилготой.

2.6.3 Биологийн төрөл зүйлийн олон янз байдал ба тогтвортой хөгжил

Цөлжилттэй тэмцэх олон улсын конвенци (1996 оны 12-р сарын 26-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Энэхүү Конвенцийн зорилго нь ноцтой хуурайшилт буюу цөлжилттэй тулгараад байгаа улс орнуудад бүхий л түвшинд үр дүнтэй арга хэмжээг авч олон улсын хамтын ажиллагааны дэмжлэг туслалцаатайгаар цөлжилттэй тэмцэх, хуурайшилтын үр нөлөөг бууруулахад оршино.

Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын тухай конвенци (1993 оны 9-р сарын 30-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын тухай Конвенци нь тогтвортой хөгжлийг дэмжин дараах гурван үндсэн зорилгыг өмнөө тавьдаг: биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалах, тэдгээрийн тогтвортой ашиглалт, генетикийн нөөцийг ашигласнаас олох орлогыг тэгш шударгаар хуваарилах.

2.6.4 Эрчим хүч ба уур амьсгалын өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн үндэсний байгууллагын суурь конвенци (1994 оны 3-р сарын 21-нээс Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Энэ Конвенцийн зорилго нь агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг дэлхийн уур амьсгалд ноцтой нөлөөлөл үзүүлэхгүй байх хэмжээнд байлгахад оршино.

Киотогийн протокол (2005 оны 2-р сарын 16-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Киотогийн протокол нь аж үйлдвэр өндөр хөгжсөн 37 оронд (Монгол улс багтаагүй) болон Европын Холбоонд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах заавал биелүүлэх зорилгуудыг тавьсан. Үүнд, хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгахад туслах гурван механизм багтсан: ялгаруулалтын худалдаа; цэвэр хөгжлийн механизм; хамтын хэрэгжүүлэлт.

Эрчим хүчний чартерын гэрээ (2000 оны 2-р сарын 17-ноос Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Гэрээ нь эрчим хүчний зах зээлийн үйл ажиллагааг ил тод, үр ашигтай байлгах зорилготой бөгөөд дараах заалтуудтай: (i) гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах; (ii) эрчим хүчний худалдаанд ялгаварлан гадуурхалгүй нөхцөл байдал; (iii) маргаан шийдвэрлэлт ; ба (iv) эрчим хүчийг ариг гамтайгаар хэрэглээг дэмжин, эрчим хүчний үйлдвэрлэл болон хэрэглээнээс үүдэн үүсэх байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах.

Эрчим хүчний үр ашиг болон холбогдох байгаль орчны нөлөөллүүдийн талаарх эрчим хүчний чартерын протокол (2000 оны 3-р сарын 19-нд Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Энэ протокол нь эрчим хүчийг ариг гамтай хэрэглэх болон эрчим хүчний системээс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах бодлогын зарчмуудыг тодорхойлсон.

2.6.5 Озоны давхаргыг устгах бодисууд

Венийн конвенци ба монреалын протокол (1996 оны 6-р сарын 5-наас Монгол Улсад хүчин төгөлдөр болсон)

Венийн Конвенци нь агаар мандал дахь озоны давхаргын нимгэрэлтээс үүдэн гарч буй сөрөг нөлөөллүүдээс хүний эрүүл мэнд болон байгаль орчныг хамгаалах улс орнуудын үүргийг тоймлон Монреалийн Протоколоор харилцан тохиролцсон цар хүрээг тодорхойж өгсөн.

1987 онд батлагдаж, 1990, 1992 онуудад нилээд хэмжээний өөрчлөлт оруулсан Монреалийн Протокол нь агаар мандал дахь озоны давхаргыг нимгэрүүлэхэд нөлөөлж буй тодорхой нэгдлүүдийн үйлдвэрлэл ба хэрэглээг шат дараалан зогсоох талаар заасан байдаг.

2.6.6 Аюултай бодисууд

Аюултай зарим химийн бодис болон пестицидийн олон улсын худалдаалааны талаар урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай роттердамын конвенц (2001 оны 3-р сарын 8-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Энэ конвенц нь эрүүл мэнд болон байгаль орчин аюултайн улмаас гишүүн орнуудад хориотой буюу хязгаарлагдсан болон оролцогч талуудад урьдчилан мэдэгдэж зөвшилцөх журманд оруулахаа мэдэгдсэн пестицид болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдах химийн бодисуудыг хамруулсан. Урьдчилан мэдэгдэж зөвшилцөх журмын дагуу оролцогч талууд жагсаалтад заагдсан химийн бодисуудын цаашдын импортыг зөвшөөрөх эсэх талаар урьдчилан мэдээлэл авсны үндсэн дээр шийдвэр гаргах боломжтой болж байгаа юм.

Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай стокгольмын конвенци (2004 оны 4-р сарын 30-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Энэхүү конвенцийн зорилго нь байгальд удаан хугацааны турш задардаг, газарзүйн хувьд өргөн тархалттай, хүний болон амьтдын биед хуримтлагддаг органик бодисуудаас хүний эрүүл мэнд болон байгаль орчныг хамгаалахад оршино.

2.6.7 Ус

БНХАУ – Монгол улсын засгийн газруудын хоорондох хил дамнасан усыг хамгаалах ба ашиглах тухай гэрээ (1994 оны 4-р сарын 29-нөөс хүчин төгөлдөр болсон)

Энэ Гэрээ нь хэд хэдэн хил дамнасан гол, нуурууд болон Хятад ба Монгол улсын хилээр хөндлөн гарсан гүний ус зэрэгт хамааралтай. Гэрээний холбогдох зүйлүүд нь усны бохирдолтыг багасгах; усны хамгаалалт болон зохистой хэрэглээ, хил дамнасан усыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудаар жил тутамд Талууд хоорондоо зөвлөлдөх шаардлага зэрэг болно.

2.6.8 Хог хаягдал

Аюултай хог хаягдалын хил дамнасан тээвэрлэлт ба тэдгээрийн устгалын тухай конвенци (1997 оны 4-р сарын 15-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Энэ Конвенци байгаль орчинд ээлтэй зохицуулалт болон хаягдлыг эх үүсвэрээс нь холгүй газарт устгах зэрэн хэд хэдэн зарчмуудтай. Мөн энэ конвенцид аюултай хог хаягдлыг хил дамнуулан тээвэрлэхэд хяналт тавих, түүний дотор тээврийн бичиг баримтууд болон зарим тохиолдолд, экспортолж байгаа улсаас импортлогч улсад урьдчилан бичгээр мэдэгдэх зэрэг зүйлсийг зааж өгсөн байдаг.

2.6.9 Дуу чимээ

Олон улсын иргэний агаарын тээврийн тухай конвенци – 16-р Хавсралт – Нисэх онгоцны дуу чимээ (1989 оны 10-р сарын 7-ноос Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

16-р Хавсралт нь байгаль орчныг нисэх онгоцны дуу чимээ болон нисэх онгоцны тийрэлтэт хөдөлгүүрээс ялгарах утаанаас хамгаалахад чиглэгдсэн. Нисэх онгоцнуудад тэдгээрийн төрлөөс нь хамааран өөр өөр шаардлагууд тавигддаг. Нисэх буудалд газардсан нисэх онгоцнуудад 16-р Хавсралтын шаардлагатай нийцэж байгаа эсэхийг нь тодруулах үнэлгээ хийгдэнэ.

2.6.10 Биет ба биет бус соёлын өв

Дэлхийн соёл ба байгалийн өвийг хамгаалах тухай конвенци (1990 оны 2-р сарын 2-нд Монгол улс хүлээн зөвшөөрсөн)

Энэ Конвенци нь ирээдүй үедээ зориулж соёлын ба байгалийн өвийг тодорхойлох, хамгаалах, хадгалах, тайлбарлан таниулах, өвлүүлэн өгөх зэрэг асуудлуудыг зохицуулдаг.

Биет бус соёлын өвийг хамгаалах тухай конвенци (2005 оны 6-р сарын 29-нд Монгол улс баталсан)

Энэ Конвенци нь дараах зүйлсийг багтаасан материаллаг бус соёлын өвийг хамгаалахад анхаарлаа хандуулдаг: хэл; хөгжим; дуу; урлагийн гүйцэтгэх төрлүүд; нийгмийн зан заншил; мөргөл

ёслол ба үндэсний баяр наадам; уламжлалт гар урлал ба мэдлэг байгаль ертөнцтэй холбоотой ёс заншил.

2.6.11 Хөдөлмөрийн харилцаа ба ажилчдын эрх

Монгол улс нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагад (ОУХБ) 1968 онд элссэн бөгөөд ОУХБ-ын хэд хэдэн конвенцид нэгдэн орж соёрхон баталсан. Үүнд:

- Албадан хөдөлмөрийн тухай конвенц, 1930 он, (№ 29), 2005 оны 3-р 15-нд соёрхон баталсан;
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай конвенц, 1948 он, (№ 87) 1969 оны 6-р 3-нд соёрхон баталсан;
- Байгууллага байгуулах эрх ба Хамтын хэлэлцээр хийх эрхийн тухай конвенц, 1949 он, (№ 98), 1969 оны 6-р 3-нд соёрхон баталсан;
- Эрх тэгш цалин хөлс олгох тухай конвенц, 1951 он (№ 100), 1969 оны 6-р 3-нд соёрхон баталсан;
- Эхчүүдийг хамгаалах тухай конвенц, 1952 он (№ 103), 1969 оны 6-р 3-нд соёрхон баталсан;
- Албадан хөдөлмөр эрхлүүлэлтийг халах тухай конвенц, 1957 он (№ 105); 2005 оны 3-р 15-нд соёрхон баталсан;
- Ялгаварлан гадуурхлын (ажил мэргэжил ба хөдөлмөр эрхлэлт) тухай конвенц, 1958 он (№ 111), 1969 оны 6-р 3-нд соёрхон баталсан;
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай конвенц, 1964 он (№ 122), 1976 оны 11-р 24-нд соёрхон баталсан;
- Хөдөлмөрийн (Газрын гүний ажил) насны доод хязгаарын тухай конвенц, 1965 он (№ 123), Насны доод хязгаарыг 18 гэж заасан. 1981 оны 12-р 3-нд соёрхон баталсан;
- Ажилчдын төлөөлөгчдийн эрхийг тухай конвенц, 1971 он, (№ 135), 1996 оны 10-р 8-нд соёрхон баталсан;
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай конвенц, 1973 он, (№ 138) Хөдөлмөрийн насны доод хязгаарыг 15 гэж заасан. 2002 оны 12-р 16-нд соёрхон баталсан;
- Гурван талт (Олон улсын Хөдөлмөрийн стандартууд) хэлэлцүүлэгийн тухай конвенц, 1976 он (№ 144), 1998 оны 8-р 10-нд соёрхон баталсан;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа ба эрүүл ахуйн тухай конвенц, 1981 он (№ 155), 1998 оны 2-р 3-нд соёрхон баталсан;
- Мэргэжлийн хөдөлмөрийн чадварыг сэргээх ба хөдөлмөр эрхлэлтийн (Тахир дутуу хүмүүс) тухай конвенц, 1983 он, (№ 159), 1998 оны 2-р 3-нд соёрхон баталсан;

2.6.12 Мал аж ахуйн үйлдвэрлэл

Ази, номхон далайн бүсийн мал амьтны үйлдвэрлэл ба эрүүл мэндийн зөвлөлийг байгуулах тухай гэрээ (2007 оны 5-р сарын 8-наас Монгол улсад хүчин төгөлдөр болсон)

Энэ Зөвлөлийн зорилтуудад мал аж ахуйн хөгжлийг дэмжих; үндэсний болон бүсийн мал аж ахуйн хөтөлбөрүүдийг боловсруулах; мал аж ахуйг үйлдвэрлэлийг салбарынх нь хувьд дэмжих; жижиг фермерийн аж ахуй эрхлэгчид болон хөдөөгийн оршин суугчдын хүнсний хэрэглээг болон амьдралын түвшинг дээшлүүлэх зэрэг асуудлууд багтана.

2.7 ОЮУ ТОЛГОЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

Энэ хэсэгт Оюу Толгой төсөл, төслийн хөрөнгө оруулагчид болон Монгол улсын Засгийн газар хоорондын харилцааг зохицуулах Хөрөнгө оруулалтын гэрээний (ХӨОГ) заалтууд дурьдагдсан байгаа. ХӨОГ нь олон нийтэд нээлттэй баримт бичиг бөгөөд энэхүү БОННБҮ-ний тайлангийн II-р ботид дахин дурьдагдсан болно. ХӨОГ-ний холбогдох заалтуудыг доорх байдлаар тоймлон үзүүлэв.

2.7.1 Оршил

Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ) нь 2009 оны 10-р сарын 6-ны өдөр байгуулагдсан бөгөөд ХӨОГ-ний урьдчилсан нөхцөлүүдийг 2010 оны 3-р сарын 31-ний өдөр хангасан. Уг гэрээг: (1) Монгол улсын Засгийн газар, түүнийг төлөөлж Сангийн сайд, Эрдэс баялаг эрчим хүчний сайд ба Байгаль орчин, аялал жуулчлалын сайд; (2) Айвенхоу Майнз Монголия Инк ; (3) Айвенхоу Майнз Лимитед; ба (4) Рио Тинто Интернейшнл Холдингс Лимитед (“**Хөрөнгө оруулагч**”) зэрэг талуудын хооронд Ашигт малтмалын тухай хуулийн 29-р зүйлд заасны дагуу байгуулав. ХӨОГ-ний нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийг бууруулах болон менежменттэй холбоотой заалтуудын талаар энэхүү дэд бүлэгт өгүүлэв.

2.7.2 Үндсэн үйл ажиллагаа

ХӨОГ-ний дагуу “Үндсэн үйл ажиллагаа” гэдэгт Уурхайн лицензийн бүсэд (“Гэрээт бүс” гэгдэх бөгөөд 6709А, 6708А ба 6710А уурхайн лицензийн талбай багтана) ашигт малтмалын хайгуулын ажлыг болон олборлолтын үйл ажиллагааг явуулах зорилгоор дэд бүтэц болон холбогдох байгууламжийг барих болон ашиглах, мөн бусад холбогдох үйл ажиллагаа (тухайлбал усан хангамж болон баяжмалын тээвэрлэлт г.м) хамаарна.

ХӨОГ-ээр Хөрөнгө оруулагч талд олборлолт хийх болон ашигт малтмалыг боловсруулах, баяжуулах үйл ажиллагааг явуулах эрхийг олгож байгаа юм. Хөрөнгө оруулагч тал нь Монгол улсын болон олон улсын стандартад нийцсэн орчин үеийн олборлох ба баяжуулах технологийг ашиглан хайгуул, олборлолт болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг үр ашигтайгаар, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц хэмжээнд байхаар удирдан явуулах үүргийг хүлээсэн.

2.7.3 Бүсийн хөгжил

Засгийн газар нь “Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл (“**Зөвлөл**”)-ийг байгуулан үйл ажиллагааг нь удирдах болно. Зөвлөлийг Засгийн газар, орон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, хандивлагч болон олон улсын санхүүгийн байгууллагын төлөөлөгчдөөс бүрдэх Удирдах зөвлөл удирдах бөгөөд Зөвлөл нь Өмнийн говийн бүс рүү чиглэсэн үйл ажиллагаануудыг явуулах болно. Хөрөнгө оруулагч нь Зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн байх ба Зөвлөл болон түний үйл ажиллагааны талаар тайлагнана.

Зөвлөл нь Өмнийн говийн орон нутгийн болон бүсийн хөгжлийн стратеги, төлөвлөгөө ба төсөв зэргийг боловсруулан бэлтгэх, санхүүжилт босгох, зохион байгуулах ба хэрэгжүүлэх зэрэг чиглэлүүдээр Засгийн газарт тусалж байх юм.

Хөрөнгө оруулагч тал нь дараах үүргийг өөртөө хүлээж байна:

- Нийгэм - эдийн засаг, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тодорхойлсны дагуу Оюу Толгой төслийн тогтвортой үр ашгийг Монгол хүмүүст, юуны өмнө Өмнөговь аймгийн оршин суугчид болон Оюу Толгой төслийн шууд ба шууд бус нөлөөллөлд өртсөн бүлгүүдэд хүртээх баталгааг бий болгож чадахуйц түншлэлийн харилцааг бий болгох;
- Орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтын ажиллагааны гэрээнүүдийг байгуулах ба үүнд орон нутгийн хөгжил ба оролцооны сангууд, орон нутгийн оролцооны зөвлөл, орон нутгийн байгаль орчны хяналт шинжилгээний зөвлөлүүд зэргийг байгуулах ажлууд багтаж болно;
- Орон нутгийн засаг захиргааны байгууллагатай Оюу Толгой төслийн шууд нөлөөллөлд өртсөн, Гэрээт Бүсэд² байршдаг малчин айл өрхүүдэд, нүүлгэн шилжүүлэлтэй холбоотой зохих ёсны нөхөн олговрыг олгох асуудлаар зөвлөлдөх;
- Ажиллах хүчээ бүртгэх, сургаж бэлтгэх, ажилд авахдаа Өмнийн Говийн бүсийн, түүний дотор Өмнөговь аймгийн харьяат иргэдэд давуу эрхийг олгох;
- Оюу Толгой төсөл болон Монгол улсын зах зээлд бараа бүтээгдэхүүнээ нийлүүлдэг орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг байгуулах, хөгжихөд нь туслах бизнес хөгжлийн хөтөлбөрүүдийг дэмжих; ба

² ХӨОГ-нд 6709А, 6708А, 6710А дугаартай уурхайн лицензийн талбайг Гэрээт бүс хэмээн тодорхойлсон.

- Төрийн бус байгууллагууд, иргэний бүлгүүд, иргэний зөвлөлүүд болон бусад оролцогч талуудтай ил тод, хариуцлагатай, оновчтой, итгэлтэй, хүндэтгэлтэй бөгөөд бие биеийн эрх ашгийг хүндэтгэсэн зарчимд үндэслэсэн харилцааг бий болгон хөгжүүлэх.

Оюу Толгой төсөл нь ХөОГ-ний бүсийн хөгжлийн талаарх заалтуудыг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаарх мэдээллийг уг БОННБҮ-ий *D Хэсэг: Менежментийн төлөвлөгөөнүүд*-ээс үзнэ үү.

2.7.4 Байгаль орчин

ХөОГ-нд багтсан байгаль орчны талаарх олон заалтууд нь Ашигт малтмалын тухай хууль болон Усны тухай хуулийн шаардлагуудыг хангасан байдаг бөгөөд хөрөнгө оруулагч тал нь энэхүү хуулийн заалтуудыг биелүүлэх гэрээний үүргийг хүлээн зөвшөөрч байгаа юм. Байгаль орчны талаарх заалтуудыг дараах байдлаар нэгтгэж болох юм:

- Хөрөнгө оруулагч тал нь Монгол улсын нэгдэн орсон Олон улсын байгаль орчны гэрээ хэлэлцээрүүд болон Ашигт малтмалын тухай хуулийн 35, 37-р зүйлүүдийг биелүүлэхийг зөвшөөрч байгаа ба Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ) хийлгэхийг зөвшөөрч байна;
- Хөрөнгө оруулагч тал нь Төрийн захиргааны төв байгууллагад БОНБНҮ-ний тайланг эцэслэн хүлээлгэн өгөхөөс өмнө уг тайланг үзэж, саналаа тусгуулах эрхтэй;
- Хөрөнгө оруулагч тал нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулинд заасны дагуу Оюу Толгой төслийн үйл ажиллагаанд шаардагдах бүх зөвшөөрөл болон лицензүүдийг авахыг зөвшөөрч байгаа ба Засгийн газраас Монгол улсын хуулийн дагуу тухайн зөвшөөрлүүдийг авахад нь дэмжлэг үзүүлнэ;
- Хөрөнгө оруулагч тал нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гүйцэтгэлийн тайланг гурван жил тутамд гарган өгч байхыг зөвшөөрч байна³;
- Хөрөнгө оруулагч тал нь БОХТ болон бусад тайлангуудыг олон нийтэд нээлттэй байлгахыг зөвшөөрөн, орон нутгийн оршин суугчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах;
- Орон нутгийн байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж байгаа нөлөөллийн талаар орон нутгийн оршин суугчдын дунд тогтмол хэлэлцүүлэг хийж байхыг зөвшөөрч байна;
- Хөрөнгө оруулагч нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төсвийн 50%-тай (тавин хувь) тэнцэх урьчилгаа төлбөрийг тухайн жилийн эхэнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын заасан банкны дансанд байршуулахыг зөвшөөрч байна;
- Хөрөнгө оруулагч нь тухайн жилийн БОХТ-гөө бүрэн хэмжээгээр нь биелүүлсэн тохиолдолд байршуулсан урьдчилгаа төлбөрийг буцаан олгоно;
- Хэрэв Хөрөнгө оруулагч нь тухайн жилийн БОХТ-д тусгагдсан арга хэмжээг бүрэн хэмжээгээр биелүүлж чадаагүй тохиолдолд байршуулсан урьдчилгаа төлбөрийг БОХТ-г гүйцээн хэрэгжүүлэхэд зарцуулах болно. Хэрэв энэ урьдчилгаа төлбөр нь хүрэлцэхгүй бол, Хөрөнгө оруулагчаас нэмэлт санхүүгийн эх үүсвэр гаргах хэрэгтэй эсэхийг тодорхойлох мэргэжилтнүүдийг томилно;
- Хөрөнгө оруулагч тал нь Үндсэн үйл ажиллагаануудын өргөн хүрээтэй байгаль орчны хяналт шинжилгээ, судалгааны хөтөлбөрүүдийнхээ тайланг жил бүр байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гарган өгөхийг зөвшөөрч байна;

³ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь БОНБНҮ-ний тайлангийн хэсэг юм. Энэ нь Монгол улсын хуулийн дагуу БОНБНҮ -д тодорхойлогдсон асуудлуудыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг тусгасан байдаг. БОХТ-г жил болгон гаргах хяналт шалгалтын талангийн үндсэн дээр Байгаль орчин Аялал Жуулчлалын Яамтай тохиролцсон төсвөөр дэмжигдэнэ. Төсвүүдийг (болон үйл ажиллагааг) жил болгон хянаж зөвшилцөх болно. Гурван жил тутмын тайлан нь хэрэгжих хугацааны гүйцэтгэлийг үнэлж тайлагнах боломжтой үйл ажиллагаа болон дэвшлийн стратегийн тойм үнэлгээгээр хангана.

- Хэрэв байгаль орчны мониторинг ба судалгаа шинжилгээний хөтөлбөрүүдийн явцад бодит сөрөг нөлөөлөл илэрвэл, Хөрөнгө оруулагч нь өөрийнхөө зардлаар энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авна;
- Оюу Толгой төслийн үйл ажиллагааны улмаас урьдчилан тооцоологдоогүй, эргэн нөхөгдөшгүй экологийн хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө оруулагч тал нь нөхөн төлбөрийг Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль дүрэмд заасны дагуу бүрмөсөн сүйтгэгдсэн байгалийн нөөцийн экологи, эдийн засгийн үнэлгээн дээр нь үндэслэн төлөхийг зөвшөөрч байна;
- Дээрх нөхөн төлбөрийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон байгаль орчны мэргэжилтнүүдийн хараат бус баг тодорхойлох бөгөөд энэ ажилд Хөрөнгө оруулагчийн саналыг харгалзан үзэж, Хөрөнгө оруулагч талтай хамтран ажиллах ёстой; ба
- Хөрөнгө оруулагч тал нь Оюу Толгой төслийн хэрэгжих хугацааны туршид өөрийн нээн олсон усны эх үүсвэрийг төсөлтэй хамааралтай барилга байгууламжийг барьж байгуулах, түүнийг ашиглалтанд оруулах, үйлдвэрлэл явуулах болон нөхөн сэргээлт хийх зэрэг ажлуудын хэрэгцээнд хэрэглэх болон ашиглах эрхтэй (түүний дотор Ус ашиглах зөвшөөрөл авсан усны нөөцүүд багтана). Дараах заалтууд нь өөрийн нээн олсон усны нөөцөнд хамааралтай . Үүнд:
 - Нээн олсон усны нөөцийн зөвшөөрөгдхн хэмжээ нь (Усны зөвшөөрөлд заасны дагуу) Оюу Толгой төслийн усны хэрэгцээг хангахад хүрэлцээтэй байх ёстой бөгөөд ийм усны нөөцийг ашиглах эрхийг бусад этгээдүүдэд шилжүүлж болохгүй.
 - ХөОГ батлагдсаны дараа нээгдсэн усны нөөц нь төслийн хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй илүү гарч байгаа тохиолдолд, усны асуудал эрхэлсэн төв байгууллага нь Хөрөнгө оруулагчтай тохиролцсоны үндсэн дээр ийм усны нөөцийг ашиглуулах зөвшөөрлийг бусад этгээдэд өгч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн этгээдэд ашиглуулахаар болсон усны нөөцийн хувь хэмжээн дээр үндэслэн хайгуулын ажлын төлбөрийг Хөрөнгө оруулагчид нөхөн олгуулах болно.
 - Хөрөнгө оруулагч тал нь өөрийн илрүүлсэн усны нөөцийг сумын ард иргэд болон малчдад ахуйн хэрэгцээнд болон тариалангийн зориулалтаар ашиглуулахыг зөвшөөрнө.
- Хөрөнгө оруулагч нь уурхайг ашиглах болон ашигт малтмалыг олборлох зорилгоор нээн ашигласан гадаргын болон гүний усны төлбөрийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ус болон рашааны ашиглалтын төлбөрийн тухай хуулийн дагуу төсөвт төлөх бөгөөд энэ төлбөрийг Хөрөнгө оруулагчийн татвар ноогдуулах орлогоос хасагдах зардал гэж авч үзэж болох боловч энэ төрлийн төлбөр болон Хөрөнгө оруулагчийн усыг ашиглах нөхцөлүүд нь дотоодын болон гадаадын бусад хэрэглэгчдэд үзүүлдэг хөнгөлөлтүүдээс дутахгүй хэмжээний хөнгөлөлт үзүүлэх ёстой бөгөөд тэрхүү ус нь аж ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээнд тохирч байгаа эсэхийг харгалзан үзэх ёстой.
- Хөрөнгө оруулагч нь БОНБНУ-нд тусгагдсаны дагуу Оюу Толгой төслийн шууд нөлөөлөлд өртөх сумын төвд ундны усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг байгуулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.
- Өөрийн нээн илрүүлсэн усны чанар нь янз бүр байж болох тул, Хөрөнгө оруулагч нь тухайн усны нөөцийг орон нутгийн иргэдийн ахуйн болон тариалангийн үйл ажиллагаанд ашиглахад нь зориулан ус боловсруулан цэвэршүүлэх ажлыг хийхэд Засгийн газарт туслалцаа үзүүлэх ба зөвхөн орон нутгийн аж ахуйн хэрэглээнд зориулсан ус дамжуулах дэд бүтцийн асуудлыг нь шийдэж өгнө.
- Усны хууль, Ус ба рашааны төлбөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу Хөрөнгө оруулагчийн хүсэлтээр Ус ашиглуулах гэрээ (зөвхөн ус ашиглах зөвшөөрлийг авсан усны нөөцүүдийн хувьд) байгуулах тал дээр Засгийн газар баталгаа гаргаж өгнө. Оюу Толгойн орд нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэсэн ангилалд багтах тул Хөрөнгө оруулагч талтай байгуулж байгаа Ус ашиглуулах гэрээг Усны тухай хуулийн дагуу гучин жилийн хугацаатай хийх бөгөөд, хорин жилийн хугацаагаар 2 удаа сунгаж болно.
- Засгийн газар нь Оюу Толгой төслийн үйл ажиллагааны усны хэрэглээг нь тасалдуулахгүй байх үүднээс Хөрөнгө оруулагч талын хүсэлт гаргаснаас хойш 30 хоногийн дотор Ус

ашиглуулах гэрээг байгуулан, ус ашиглахтай холбоотой бусад зөвшөөрлүүдийг гаргаж өгнө; ба

- Хөрөнгө оруулагч тал нь ус ашиглахтай холбоотойгоор дараах үүргүүдийг хүлээх болно:
 - Усны тухай хуулийн 24-р зүйл, Ус ашиглуулах гэрээ, БОНБНУ зэрэгт заагдсан бүх нөхцөл шаардлагуудыг бүрэн биелүүлэх ёстой бөгөөд эдгээр нөхцөл шаардлагуудын хэрэгжилтийг 5 жил тутамд, энэ хугацааны сүүлийн жил дууссанаас хойш 3 сарын дотор бие даасан, чадварлаг, мэргэжлийн компаниар шалгуулж байх бөгөөд шалгалтын дүнг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгөх ба нэг хувийг нь Хөрөнгө оруулагчид үлдэх болно;
 - Усны нөөцийн бүсэд оршин сууж усыг нь хэрэглэж байсан хэрэглэгчдийн ундны болон мал услах усны чанар ба хэмжээг ХӨОГ-г зурагдах үед БОНБНУ-нд тодорхойлсон хэмжээнээс нь бууруулахгүй байлгах;
 - Оюу Толгой төслийн хэрэглэж байгаа усны хэмжээг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд орчин үеийн технологийг ашиглах, усыг ариг гамтайгаар хэрэглэх, боломжтой тохиолдолд, ижил төрлийн үйлдвэрлэлд ашиглагддаг технологийг ашиглан усыг дахин боловсруулах буюу цэвэршүүлж ашиглах;
 - Уурхайн үйл ажиллагаанд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээний хаалт хийх үед Үндсэн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон байгаль орчныг Монголын болон олон улсын стандартын дагуу нөхөн сэргээх.

Оюу Толгой ХХК нь ХӨОГ-нд заасан байгаль орчныг хамгаалах заалтуудын хэрэгжилтийн талаарх нарийвчилсан мэдээллүүдийг энэ БОНБНУ-ний *D Хэсэг: Менежментийн төлөвлөгөөнүүд-ээс* үзнэ үү.

2.7.5 Дэд бүтэц

ХӨОГ-ний дэд бүтэцтэй холбоотой заалтууд нь эрчим хүч болон тээвэрлэлтийн асуудлуудад анхаарлаа хандуулсан. Эрчим хүчний тухайд, ХӨОГ-нд Засгийн газар болон Хөрөнгө оруулагч талууд Оюу Толгой төслийн шаардлагыг хангахуйц эрчим хүчний хангамжийн хамгийн үр дүнтэй бөгөөд найдвартай шийдлийг олж тодорхойлох тал дээр хамтран ажиллана гэж заасан. Өөрөөр хэлбэл, ХӨОГ-ээр Хөрөнгө оруулагчид үйлдвэрлэлийн эхний дөрвөн жилийн хугацаанд дараах эрхүүдийг олгожээ:

- Шаардлагатай дамжуулах шугамыг барьж байгуулан Оюу Толгой төслийн эрчим хүчний хэрэгцээг Монгол улсын дотоодоос буюу гадаадаас хангах;
- Оюу Толгой төслийн урт болон богино хугацааны эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор уурхайн талбайн хамгийн боломжтой газарт эрчим хүч үйлдвэрлэх байгууламж барих; ба
- Эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай нүүрсний эх үүсвэрийг тодорхойлох.

Хөрөнгө оруулагч нь үйлдвэрлэлээ эхлүүлсэнээс хойш дөрвөн жилийн дотор Оюу Толгой төслийн эрчим хүчний хэрэгцээг Монгол улсын дотоодоос, дараах нэг буюу түүнээс дээш эх үүсвэрүүдээс хангадаг болох ёстой:

- Хөрөнгө оруулагчийн байгуулсан буюу хөрөнгө оруулсан нүүрсний цахилгаан станц;
- Гуравдагч этгээдийн байгуулсан буюу хөрөнгө оруулсан нүүрсний цахилгаан станц; эсвэл
- Монгол улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээ.

Засгийн газраас төслийг эрчим хүчээр хангах тохиолдолд уг хангамж нь арилжааны хэлбэртэй буюу үнэ тарифийн хувьд ялгаварлан гадуурхахгүй байх үндсэн дээр явагдах ёстой бөгөөд Оюу Толгой төслийг тогтвортой, найдвартай, тасалдалгүй эрчим хүчээр хангах ёстой.

Засгийн газар нь төсөлд эрчим хүчний хангамжийн зөвшөөрлийг Монгол улсын хуулинд заагдсан хамгийн урт хугацаатайгаар, боломжит хамгийн түргэн хугацаанд олгох баталгааг өгнө.

Хөрөнгө оруулагч тал нь Оюу Толгой – Гашуунсухайтын хооронд хил хүртэлх авто зам барьж болох ба, тээвэрлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай дараах нөхцөлөөр гэрээ байгуулж болно:

- Оюу Толгой төслөөс Гашуунсухайт хүртэлх хил хүртэлх замын маршрутыг Засгийн газартай хэлэлцэн тохиролцож шийдэх ба энэ маршрут нь өртөг зардлын хувьд хамгийн үр ашигтай, боломжит хамгийн шулуун чиглэлтэй байх ёстой;
- Хөрөнгө оруулагч тал нь зам барилгын ажлын санхүүжилтийг хийх бөгөөд энэ замыг ашиглаж байгаа бүх хэрэглэгчдээс төлбөр авахгүй байх; ба
- Засгийн газар нь замын засвар үйлчилгээг хариуцах болно.

Замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Хөрөнгө оруулагч тал нь замын засвар үйлчилгээний ажлыг Хөрөнгө оруулагч талд өөрийнх нь санхүүжилтээр гүйцэтгүүлэх заалт бүхий гэрээг байгуулна.

Хөрөнгө оруулагч нь Монгол улсын хуулийн дагуу зөвшөөрөл авсны үндсэн дээр төслийн үйл ажиллагааны хүрээнд нисэх онгоцны буудлыг барьж байгуулан ашиглаж болно.

Засгийн газар нь төслийн ойр орчмын газар нутгийг дайруулан Хятад-Монголын хил хүртэл төмөр зам байгуулах, байгуулагдсан төмөр замыг удирдан ажиллуулж болно. Төмөр замын байршил болон маршрутын талаар Засгийн газар нь Хөрөнгө оруулагчтай зөвлөлдөх бөгөөд энэхүү төмөр замыг байгуулбал түүнийг Хөрөнгө оруулагч талд цэвэр арилжааны, тарифийн хувьд ялгаварлан гадуурхахгүй байх нөхцөлөөр ашиглуулна.

Оюу Толгой ХХК нь ХөОГ-ний дэд бүтэцтэй холбоотой заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх нарийвчилсан мэдээллийг энэ БОННБҮ-ий *Хэсэг D: Менежментийн Төлөвлөгөөнүүд*-ээс үзнэ үү.

2.7.6 Хөдөлмөрийн харилцаа, ажил эрхлэлт ба сургалт

ХөОГ-ний хөдөлмөрийн харилцаа болон ажил эрхлэлтийн олон заалтуудад Монгол улсын холбогдох хуулиудын заалтуудыг тусгасан бөгөөд Хөрөнгө оруулагч тал нь тэдгээр хуулийн заалтуудыг биелүүлэх үүргийг хүлээсэн байна. Тэдгээр хуулиудыг *Бүлэг B13*-т авч үзсэн тул энд давтан дурдахгүй.

ХөОГ-ний нөхцөлийн дагуу Хөрөнгө оруулагч ба Засгийн газар нь Оюу Толгой төслийн цаг хугацааны хүрээнд багтаахын тулд зохих ёсоор мэргэшсэн ажиллах хүчний нөөцийг байнга байлгана гэсэн баталгааг өгнө. Дараах үйл ажиллагаануудыг гэрээнд мөн зааж өгсөн:

- Гэрээ хүчин төгөлдөр болсноос (ХөОГ-нд заасны дагуу) хойш 90 хоногийн дотор Хөрөнгө оруулагч тал нь Оюу Толгой төсөлд чадварлаг Монгол ажилчид бэлтгэхэд чиглэгдсэн сургалтын стратеги ба төлөвлөгөөг таван жилээр нь гаргаж Засгийн газарт өргөн барих бөгөөд олон нийтэд зарлана;
- Хөрөнгө оруулагч нь Монгол улсын иргэдийг уул уурхайн салбарт тэр дундаа инженерийн чиглэлээр боловсрол эзэмшихэд туслах тэтгэлэгт магистрийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ;
- Оюу Толгой төслийн ажилтнууд олон улсын стандартаар бэлтгэгдсэн байх явдлыг баталгаажуулахын тулд гэрээний хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор сонгогдсон Монголын их сургуулиуд болон техник мэргэжлийн сургуулиудад олон улсын уул уурхайн сургалт болон бэлтгэл сургалтын хөтөлбөрийг зохион явуулахад Засгийн газар дэмжлэг тусалцаа үзүүлэх болно.

Оюу Толгой ХХК нь ХөОГ-ний хөдөлмөрийн харилцаа, ажил эрхлэлт болон тэднийг сургаж бэлтгэх талаарх заалтуудыг хэрхэн биелүүлж байгаа талаарх нарийвчилсан мэдээллийг энэхүү БОННБҮ-ий *D Хэсэг: Менежментийн Төлөвлөгөөнүүд*-ээс үзнэ үү.

2.7.7 Засгийн газрын нэмэлт үүрэг амлалтууд

Хөрөнгө оруулагчийн хүсэлтээр гадаадын иргэдийг Оюу Толгой төсөлд ажиллуулахаар оруулж ирэхэд шаардлагатай бүхий л зөвшөөрлийг хурдан шуурхай олгох тал дээр Засгийн газраас дэмжлэг үзүүлэх болно.

Оюу Толгой төслийн үйл ажиллагаанд яамны эсвэл Засгийн газрын зөвшөөрөл буюу зохицуулалт шаардагдаж байгаа тохиолдолд болон ХөОГ-ний дагуу Хөрөнгө оруулагч тал нь Засгийн газарт хүсэлт гаргавал түүнийг нь шалтгаангүйгээр дарагдуулах буюу саатуулахгүй байх болно.

Засгийн газар нь Гашуунсухайтын шалган өнгөрүүлэх газрыг олон улсын хилийн боомт болгож, нээлттэй, байнгын үйл ажиллагаа явуулдаг боомт болгох талаар өөрөөс хамаарах бүхнээ хийх болно.

2.8 ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Энэхүү БОННБУ нь бас төслийн боломжит зээлдүүлэгчид болох олон улсын санхүүгийн байгууллагуудаас тавьдаг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн талаарх шаардлагуудыг мөрдөж ажиллаж байгаа талаар нотлосон. Энэхүү БОННБУ-нд ОУСБ-уудын дараах шаардлагуудыг дурдсан болно:

- Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн Нийгэм, байгаль орчны тогтвортой байдал, 2006, түүний дотор ОУСК-н Гүйцэтгэлийн стандартууд (ГС) болон Байгаль орчин, Эрүүл мэнд ба Аюулгүй ажиллагааны (БОЭМАА) зааварчилгаа;
- Европын сэргээн босголт ба хөгжлийн банкны (ЕСБХБ) Байгаль орчин ба Нийгмийн бодлого, 2008, түүний дотор ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) ба Байгаль орчны Европын холбооны зарчмууд (БОЕХЗ);
- Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын Байгаль орчин ба албан ёсоор дэмжигдэх экспортын зээлийн талаарх ерөнхий аргачлалын зөвлөмж, 2007;
- Экваторын зарчимууд, 2006; ба
- Стандарт чартер банкны Уул уурхай, металлургын салбар, Байр сууриа илэрхийлэх мэдэгдэл (шинэчлэгдсэн) гаргах.

2.8.1 ОУСК-ийн шаардлагууд

ОУСК-ийн Нийгэм ба байгаль орчны тогтвортой байдлын бодлого⁴ нь ОУСК-аас санхүүжүүлж байгаа төслүүдэд тавигдах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон нийгмийн шаардлагуудыг тогтоож өгдөг. Экваторын зарчмыг хэрэгжүүлснээр, ОУСК-ийн шаардлагууд нь *үнэн хэрэг дээрээ* төслийн санхүүжилтэд тавигдах байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг үнэлэх олон улсын хэмжүүр болсон юм. ОУСК-ийн шаардлагууд нь доор хураангуйлан үзүүлсэн өөрийн Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандартуудад тусгагдсан. Гүйцэтгэлийн стандартуудыг бас тодорхой салбар бүрийн байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамжуудаар дэмждэг бөгөөд эдгээрээс уул уурхай, нисэх онгоцны буудал, хог хаягдлын менежментийн байгууламжууд болон ус, эрүүл ахуйн ерөнхий удирдамжууд нь төсөлд хамгийн их хэрэглэгдэх юм. Энэ хэсэгт мөн Гүйцэтгэлийн стандартад энэхүү БОННБУ нь хэрхэн зохицож байгааг дурдаж өгсөн:

ГС 1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ ба менежментийн систем

Гүйцэтгэлийн Стандарт 1 /ГС/ нь төсөл хэрэгжих бүхий л хугацаанд нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийг нийгэм, байгаль орчны давшингуй менежментийн системийг ашиглан удирдахыг чухалчилдаг. Энэ Гүйцэтгэлийн Стандартын зорилтууд нь:

- Төслийн нөлөөллийн бүсэд нийгэм, байгаль орчинд үзүүлэх сөрөг ба эерэг нөлөөллүүдийг аль алийг нь тодорхойлон үнэлэх;
- Ажилчид, нөлөөлөлд өртсөн ард иргэд болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, хэрвээ зайлсхийх аргагүй бол хамгийн бага хэмжээнд хүргэн бууруулах буюу нөхөн төлбөр олгох;
- Нөлөөлөлд өртсөн ард иргэдийг тэдэнд нөлөөлөл үзүүлж болох асуудалд зохих ёсоор оролцох оролцоог нь хангах; ба
- Менежментийн системийг үр дүнтэйгээр ашиглах замаар компаниудын нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулалтыг дэмжих.

ГС1 нь БОННБУ-ий хоёр гол хэсгүүдэд анхаарлаа хандуулсан, тухайлбал, Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ (С Хэсэг) болон Төслийн байгаль орчин, нийгмийн

⁴ 2006 оны 4-р сарын 30-н

менежментийн төлөвлөгөөнүүд (D Хэсэг). Төсөлд ард иргэдийн оролцоог хангах асуудлыг Бүлэг А6: Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө гэсэн бүлэгт авч үзсэн. Энэ Бүлэгт Оюу Толгой ХХК-аас өргөн хүрээнд явуулж байгаа хэлэлцүүлгүүдийн үйл ажиллагааг тоймлон үзүүлсэн.

ГС 2: Хөдөлмөр ба ажлын байрны нөхцөл байдал

Энэхүү ГС-д харуулсан шаардлагуудын нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) болон Нэгдсэн Үндэсний Байгууллагуудын (НҮБ) хэмжээнд хэлэлцэгдсэн олон улсын конвенцуудаар хэсэгчлэн удирдагдана. Энэхүү Гүйцэтгэлийн Стандартын зорилго нь:

- Ажилчин-удирдлагын хоорондын харилцааг бий болгох, дэмжих болон сайжруулах;
- Ажилчидтай шударгаар харьцах, тэднийг ялгаварлан гадуурхахгүй ба адил тэгш боломжоор хангах үзгийг дэмжиж, тухайн улсын хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх;
- Хүүхдийн хөдөлмөр болон албадан хөдөлмөр эрхлэх зэрэг асуудлыг шийдсэнээр ажиллах хүчийг хамгаалах; ба
- Ажлын байрны эрүүл, аюулгүй нөхцөл байдлыг хангах болон ажилчдын эрүүл мэндийг хамгаалах ба дэмжих.

ГС2 нь дараахь бүлгүүдэд дурдагдсан: B9 Бүлэг: Ажил эрхлэлт ба амьжиргааны түвшин, D Хэсэг, Оюу Толгой төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө

ГС 3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба бууруулах

Энэ Гүйцэтгэлийн стандарт нь төслийн үйл ажиллагаанаас үүсэх бохирдлоос урьдчилан сэргийлэх болон бууруулах арга барилыг олон улсад хэрэглэгдэж байгаа технологи болон практиктын дагуу хэрэгжүүлэх зорилготой. Төслийн хүрээнд зах зээлд бэлэн буй технологи ба нөөцөд тулгуурлан техник ба санхүүгийн хувьд боломжтой технологи болон практикийг нэвтрүүлэх боломж, чадварыг хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог. Энэ Гүйцэтгэлийн стандартын зорилтууд нь:

- Төслийн үйл ажиллагаанаас Хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх буюу хамгийн бага хэмжээнд байлгах; ба
- Цаг уурын өөрчлөлтөнд нөлөөлдөг агаарын бохирдуулагчийн ялгаруулах хэмжээг бууруулахыг дэмжих.

ГС-3 нь дараах бүлгүүдэд анхаарлаа хандуулсан: C Хэсэг: Нөлөөллийн үнэлгээ, D Хэсэг: Шатахуун ба түлшний менежментийн төлөвлөгөө, Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, Аюултай материалын менежментийн төлөвлөгөө зэрэг багтсан Оюу Толгой төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө. Бохирдлын хяналт болон бууруулах арга хэмжээ нь байгаль орчны арга хэрэгслүүдэд хамардаг учраас энэхүү БОННБҮ-ний бууруулах арга хэмжээ ба менежментийн хэсэгт дурдагдаж өгсөн.

ГС 4: Ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал

Энэ ГС нь төслийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж болон дэд бүтэц нь ард иргэдэд ажил эрхлэлт, үйлчилгээ болон эдийн засгийн хөгжил дэвшлийн боломж зэрэг ашиг тусыг авчирдаг болохыг хүлээн зөвшөөрдөг. Хэдий тийм ч төслүүд нь осол аваарь, хорт бодисын хаягдал, өвчинд нэрвэгдэх зэргээс үүдсэн эрсдэлүүдийг ихэсгэдэг ба, хамгаалалтын ажилчдыг ашигладаг. Хүн амын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг дээшлүүлэхэд эрх баригчдын гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ энэхүү ГС нь төслийн хөрөнгө оруулагчийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын талаарх үүрэг хариуцлагуудад анхаарлаа хандуулсан. Энэ Гүйцэтгэлийн стандартын зорилтууд нь:

- Төсөл хэрэгжих хугацаанд төлөвлөгдсөн болон төлөвлөгдөөгүй нөхцөл байдлаас үүдэн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд гарч болох эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх буюу хамгийн бага түвшинд байлгах;
- Ажилчид болон эд хөрөнгийг ард иргэдийн аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдалд үзүүлж болох эрсдлээс зайлсхийсэн буюу хамгийн бага хэмжээнд байлгах баталгаат арга замаар хамгаалах.

ГС4 нь дараах бүлгүүдэд анхаарлаа хандуулсан: С13-р бүлэг: Ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал, D20-р бүлэг: Ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, болон D18-р бүлэг: Ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежментийн төлөвлөгөө. Энэ менежментийн төлөвлөгөөнд аюулгүй байдлыг ч бас авч хэлэлцсэн байгаа.

ГС 5: Газар чөлөөлөлт ба албадан нүүлгэн суурьшуулалт

Албадан нүүлгэн суурьшуулалт гэдэг нь төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор газар чөлөөлөлтөөс үүдэн бий болсон биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа юм. Албадан нүүлгэн шилжүүлэлт хийх зайлшгүй шаардлагатай тохиолдолд, нүүлгэн шилжүүлэлтэд өртөж байгаа хүмүүс болон тэднийг хүлээн авч байгаа орон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нарийн төлөвлөн гүйцэтгэнэ. Энэ Гүйцэтгэлийн Стандартын зорилтууд нь:

- Албадан нүүлгэн суурьшуулалтаас зайлсхийх буюу нөлөөллийг нь хамгийн бага байлгахын тулд боломжтой бол төслийн төлөвлөлтийн өөр хувилбаруудыг судлах;
- Газрыг чөлөөлөх буюу хэрэглээг нь хязгаарлах зэрэг нөлөөлөлд өртсөн хүмүүст үзүүлэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг багасгахын тулд: (i) эд хөрөнгөө алдсаны нөхөн төлбөрийг үнэлэн барагдуулах; ба (ii) нүүлгэн суурьшуулалтын ажиллагааг зохих ёсны нээлттэй хэлэлцүүлэг байдлаар явуулж бөгөөд нөлөөлөлд өртсөн хүмүүст мэдээлж буйг баталгаажуулах;
- Нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсийн амьжиргаа болон амьдралын түвшинг сайжруулах эсвэл наад зах нь хэвийн хэмжээнд буцаан сэргээх; ба
- Нүүж очсон газарт нь аюулгүй амьдарч болох орон байр барьж өгөх зэргээр нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн амьдралын орчин нөхцлийг сайжруулах.

Газар ашиглалт болон газар чөлөөлөлтийн асуудлыг В ба С хэсгүүдэд авч үзсэн ба энэ БОННБУ-ний D Хэсэг: Газар Ашиглалтын Менежментийн Төлөвлөгөө-нд тайлбарлагдсан.

ГС 6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын хадгалан хамгаалалт ба байгалийн нөөцийн тогтвортой менежмент

Энэ Гүйцэтгэлийн Стандартад биологийн төрөл зүйлийн тухай Конвенцийн биологийн төрөл зүйлүүдийг хадгалан хамгаалах, нөхөн сэргээгддэг байгалийн нөөцийг тогтвортой арга замаар ашиглахыг дэмжих зэрэг зорилтуудыг тусгасан байдаг. Энэ Гүйцэтгэлийн Стандартад төсөл хэрэгжүүлэгчид өөрсдийн үйл ажиллагаанаас үүдэн гарч байгаа биологийн төрөл зүйлүүдэд учруулах аюулыг хэрхэн зайлуулах буюу бууруулах мөн нөхөн сэргээгдэх байгалийн нөөцийг хэрхэн тогтвортой ашиглах зэрэгт анхаарлаа хандуулсан байдаг. Энэхүү Гүйцэтгэлийн Стандартын зорилтууд нь:

- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалан хадгалах; ба
- Тогтвортой менежмент ба байгалийн нөөцийг хадгалан хамгаалах зэргийг хамгаалан хадгалалтын хэрэгцээ болон хөгжлийн эрэмбэ зэргийг нэгтгэн хамарч чадсан үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх хэлбэрээр дэмжих.

ГС6-ийн биелүүлтийг энэхүү БОННБУ-ний хэд хэдэн бүлгүүдэд авч үзсэн. Биологийн нөөцийн суурь үнэлгээг Бүлэг В7-т тусгасан. Биологийн нөөцөд үзүүлэх нөлөөллийн талаар энэ БОННБУ-ний Бүлэг С7-т, урт хугацааны бууруулах арга хэмжээ ба хяналт шинжилгээ зэргийг агуулсан биологийн төрөл зүйлийн өвийг хамгаалах арга хэмжээг Биологийн төрөл зүйлийн Менежментийн Төлөвлөгөөнд авч үзсэн.

ГС 7: Нутгийн уугуул иргэд

Гүйцэтгэлийн Стандарт 7 нь Нутгийн уугуул иргэд гэдэгт тухайн улс оронд олонхи болж буй үндэстнээс ялгаатай, онцлог шинж чанар бүхий нийгмийн бүлгийг авч үздэг.

Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх нутгийн уугуул иргэд байхгүй тул энэ Гүйцэтгэлийн Стандартыг ашиглахгүй. Нутгийн малчид нь үндэс угсаа, соёл иргэншлийн хувьд Монгол улсын

үндэстэн ястны цөм хэсэг болсон халх монголчууд юм. Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалж буй болсон эдийн засгийн хөгжил болон нийгмийн өөрчлөлтүүд нь тэдний уламжлалт ахуй амьдралын хэв маягт дарамт шахалт үзүүлж байгаа тул энэхүү БОННБҮ-нд малчин иргэдийг “эмзэг бүлэг” хэмээн нэрлэсэн.

ГС 8: Соёлын өв

Дэлхийн соёл ба байгалийн өвийг хамгаалах тухай конвенцийн үзэл санааны хүрээнд энэ Гүйцэтгэлийн Стандарт нь орлуулж болшгүй соёлын өвийг хамгаалахад чиглэгдсэн ба төслийн хөрөнгө оруулагчдыг бизнесийн үйл ажиллагааныхаа явцад соёлын өвийг хамгаалах үйл ажиллагаа явуулахад зааварчилгаа өгдөг. Гүйцэтгэлийн стандартын зорилтууд нь:

- Соёлын өвийг төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ба тэдгээрийг хадгалан хамгаалах явдлыг дэмжих; ба
- Соёлын өвийг бизнесийн үйл ажиллагаанд ашигласан тохиолдолд олсон ашгийг нь тэгш байдлаар хувиарлах явдлыг дэмжих.

Соёлын өвийн суурь судалгаа, түүний дотор ‘биет’ ба ‘биет бус’⁵ өвүүдийн аль алиных нь талаар энэ БОННБҮ-ний Бүлэг В12-т дурдсан. Үзүүлж болох нөлөөллүүдийн талаар С хэсэгт авч үзсэн бол Тохиолдлын олдворын журам зэргийг агуулсан нөлөөлөл бууруулах арга хэмжээний боловсруулалтыг Бүлэг D13: Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө-нд авч үзсэн болно.

ОУСК-ийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамж

ОУСК нь Гүйцэтгэлийн Стандартаас гадна ерөнхий ба төслийн салбар бүрийн байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамжуудыг гаргасан. Оюу Толгой төсөлд хэрэгжих гол удирдамжуудийг дор дурдав:

- Ерөнхий байгаль орчин, эрүүл мэнд, ба аюулгүй ажиллагааны удирдамж (2007 оны 4-р сар);
- Уурхайн байгаль орчин, эрүүл мэнд, ба аюулгүй ажиллагааны удирдамж (2007 оны 12-р сар); ба
- Нисэх онгоцны буудлын байгаль орчин, эрүүл мэнд, ба аюулгүй ажиллагааны удирдамж (2007 оны 4-р сар)

Уурхайн салбарын удирдамж нь уурхайн хаалтын (түр болон бүрмөсөн, төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус) төлөвлөгөө болон санхүүгийн асуудлуудыг тодорхойлсон байдаг.

2.8.2 Европын сэргээн босголт хөгжлийн банкны шаардлагууд

ЕСБХБ нь 2008 оны өөрийн Байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу санхүүжилт авч буй төсөл нь байгаль орчин ба нийгмийн үнэлгээ болон хяналт шинжилгээний явцдаа дараах шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулахыг эрмэлздэг:

- Нийгэм, байгаль орчны хувьд тогтвортой байх;
- Нөлөөлөлд өртсөн ажилчид болон ард иргэдийн эрхийг хүндэтгэх; ба
- Холбогдох дүрэм журмын шаардлагууд болон олон улсын тэргүүлэх туршлагын дагуу төлөвлөгдөж үйл ажиллагаагаа явуулж байх.

ЕСБХБ нь эдгээр зорилгуудыг практикт амжилттай хэрэгжүүлэхийн тулд байгаль орчин, нийгэмд үзүүлэх гол нөлөөллүүд болон асуудлыг хамруулсан өргөн хэмжээний Гүйцэтгэлийн Шаардлагуудыг (“ГШ”) батлан гаргасан юм. ЕСБХБ нь Европын Холбооны байгаль орчны стандартууд болон баталсан Байгаль орчны талаарх Европын Зарчмуудыг дэмждэг тул тэдгээр нь бас энэхүү ГШ-уудад тусгагдсан болно. Энэ банк нь үйлчлүүлэгчиддээ ГШ-уудыг хангаж байхын тулд хэрэгжүүлж буй төслийнхөө байгаль орчин болоод нийгмийн асуудлуудад үнэлгээ, менежмент хийж байхыг шаарддаг.

⁵ Эдгээр нэр тоймёонуудыг БОННБҮ-ний суурь хэсэгт тодорхойлсон болно.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагуудыг доорхи байдлаар нэгтгэн үзүүлэв. ЕСБХБ-ны ГШ нь ОУСК-н стандартуудтай нягт холбоотой байдаг тул энэ БОННБҮ-нд хоёуланг адил байдлаар авч үзсэн. ЕСБХБ нь Банкны стандартуудыг хангаагүй төслүүдэд санхүүжүүлэлт олгодоггүй.

ГШ 1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба менежмент

Энэ Гүйцэтгэлийн Шаардлага нь Европын Холбооны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний удирдамжийн (85/337/ЕЕС нэмэлт өөрчлөлттэй) дагуу төслийн байгаль орчин болон нийгмийн асуудлын үнэлгээ, удирдлага ба хяналт шинжилгээний ажиллагааг тодотгосон болно. Оюу Толгой төслийг А Зэрэглэлийн Төсөл гэж ангилсан тул Байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх байдлын бүрэн хэмжээний үнэлгээ (БОННБҮ) хийлгэх шаардлагатай юм.

Байгаль орчны тухай европын зарчмууд

"Байгаль орчны тухай европын зарчмууд" (БОЕЗ) нь Европын Холбооны Гэрээнд⁶ тусгагдсан байгаль орчныг хамгаалах удирдамжууд болон Европын Холбооны байгаль орчны талаарх хуулиудад тусгагдсан онцлог туршлага болон стандартын зааварчилгаануудыг агуулдаг, тухайлбал: урьдчилан сэргийлэх зарчим, урьдчилсан арга хэмжээний зарчим, байгаль орчны хохирол нь давуу эрхтэй тул түүнийг эх үүсвэрийн хамт засан сайжруулах зарчим болон бохирдуулагч тал төлбөр төлөх ёстой гэсэн зарчмууд багтдаг. Эдгээр зарчмууд нь Европын Холбооны холбогдох хуулиудад тусгагдсан болно.

Энэхүү үнэлгээнд хэрэглэгдэх Европын Холбооны гол хуулиуд нь:

- Европын Холбооны байгаль орчны үнэлгээний хууль, гол төлөв, Заавар 85/337/ЕЕС, нэмэлт өөрчлөлт орсон;
- Төслийн тодорхой үйл ажиллагаануудад хэрэглэгдэх үйлдвэрлэлийн бохирдлын хяналт, уурхайн хог хаягдалын менежмент, томоохон ослын аюулууд, хог хаягдалын менежмент, усны менежмент, байгаль орчны хамгаалалт болон ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тухай Европын Холбооны хуулиуд зэрэг юм.

Энэхүү БОННБҮ-ний тайланг бэлтгэх явцад хэрэглэсэн ЕХ-ны байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой гол хууль тогтоомжийг дор үзүүлэв. (тайланг бэлтгэх явцад Монгол Улс нь ЕХ-д элсэх төлөвлөөгүйг харгалзан үзсэн болно.)

Агаар мандал ба Дуу чимээ

Хүрээлэн буй агаарын чанарын заавар 2008/50/ЕС

Хүнд тээврийн хэрэгслээс ялгарах утааны тухай заавар 2005/55/ес

Хүрээлэн буй орчны дуу чимээний тухай заавар 2002/49/ЕС

Шатахууны чанарын тухай заавар 2003/17/ЕС

Шингэн шатахууны хүхрийн агууламжийн тухай заавар 1999/32/ЕС

Химийн бодис

ЕХ-ны журам 1907/2006 Химийн бодисын бүртгэл, үнэлгээ, зөвшөөрөл ба химийн бодисын хязгаарлалт,

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас ялгарах утаа болон үйлдвэрийн осол аваарь

Аюултай бодистой холбоотой осол аваарийн тухай заавар 2003/105/ЕС

Үйлдвэрийн бохирдлоос сэргийлэх, хяналт тавих заавар 2008/1/ЕС

Үйлдвэрээс үүсэх хорт ялгаруулалтын тухай заавар 2010/75/EU

Хог хаягдал

Хог хаягдлын тухай ерөнхий заавар 2008/98/ЕС,

Хог хаягдлыг шатаах тухай заавар 2000/76/ЕС

Хог хаягдлыг булах (ландфил) тухай заавар 1999/31/ЕС

Уурхайн хог хаягдлын менежментийн тухай заавар 2006/21/ЕС

⁶ Европийн Холбоо байгуулах гэрээ 2002 он, 174 (2) заалт

Ус

Усны тухай ерөнхий заавар 2000/60/ЕС,

Ундны усны тухай заавар 98/83/ЕС

Хотын бохир усны боловсруулалтын тухай заавар 91/271/ЕЕС

Газрын доорх усны тухай заавар 2006/118/ЕС

Ажилчдын эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа

Ажлын байрны эрүүл ахуй ба аюулгүй ажиллагааны тухай заавар 89/391/ЕЕС

Уурхайн хог хаягдлын менежментын заавар 2006/21/ЕС-ын тохирсон нөхцөлүүдийн дагуу уурхайн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч нь уурхайг ямар нэгэн шалтгаанаар зогсоосон тохиолдолд, уурхайг түр болон бүр хугацаагаар аюулгүй байдлаар хааж болохуйц хэмжээний мөнгөн хөрөнгө байнга боломжтой байлгахыг баталгаажуулах уурхайн бүрэн санхүүжилттэй хаалтын төлөвлөгөөнүүдийг боловсруулах шаардлагатай.

ГШ 2: Хөдөлмөр ба ажиллах орчин нөхцөл

Энэ гүйцэтгэлийн шаардлага нь Төслийн үйл ажиллагааны туршид хөдөлмөр, ажиллах орчин нөхцлийн талаар хүний нөөцийн бодлого, дүрэм журам болон стандартууд нь дараах хамгийн бага шаардлагуудыг хангаж байгааг баталгаажуулдаг:

- Ажилтан-удирдлагын хоорондын сайн харилцааг тогтоон хадгалах, ажилтнууддаа шударга хандах, тэднийг ялгаварлан гадуурхахгүй байх болон адил тэгш боломжоор хангах явдлыг дэмжих; ба
- Байгуулсан бүх хамтын гэрээ, тухайн улсын хөдөлмөрийн ба ажил эрхлэлтийн хууль болон холбогдох ОУХБ-ын конвенцуудын суурь зарчмууд болон гол стандартуудыг дагаж мөрдөх; ба
- Эрүүл аюулгүй ажиллах орчныг бий болгох замаар ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалан дэмжих.

Үүнээс гадна ЕСБХБ нь холбогдох Европын Холбооны Хөдөлмөрийн эрүүл ахуй ба аюулгүй ажиллагааны шаардлагуудыг мөрдөхийг шаарддаг ба хэрэв ийм шаардлагууд байхгүй тохиолдолд, холбогдох ОУСК-ийн Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгааг дагаж мөрдөхийг шаарддаг.

ГШ 3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба түүнийг багасгах

Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба түүнийг багасгах нь тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн гол бүрэлдэхүүний нэг бөгөөд ЕСБХБ-аас санхүүжилт авч байгаа төслүүд нь энэ талын олон улсын тэргүүний туршлагыг нэвтрүүлсэн байх ёстой. Байгаль орчны бохирдолтой холбоотой нөлөөлөл ба асуудлуудыг эдийн засгийн бүхий л төрлийн үйл ажиллагаандаа анхаарч үзэх ба үйлдвэрлэлийн түвшний бохир ус ба хорт хийн ялгаруулалтын нөлөөллийг орон нутгийн болон боломжтой тохиолдолд, олон улсын хэмжээнд анхаарч үзэх хэрэгтэй юм. Энэ гүйцэтгэлийн шаардлага нь төслийн бүхий л хэтийн төлвүүд дараах зорилгуудыг хангаж байгааг бататгадаг:

- Төслийн шууд бохирдолтоос зайлсхийх буюу түүнийг хамгийн бага түвшинд байлгах замаар хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол хамгийн бага түвшинд байлгах;
- Үйлчлүүлэгчдэд төсөлтэй холбоотой эрчим хүч ба нөөц ашиглалтын үр ашгийг сайжруулах болон хог хаягдлыг багасгах боломжуудыг тодорхойлоход туслах; ба
- Төсөлтэй холбоотой хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгахад дэмжлэг үзүүлэх.

Европын Холбооны Уул уурхайн хог хаягдлын менежментийн тухай заавар (2006/21/ЕС) болон түүнтэй хамааралтай хамгийн шилдэг аргачлалын удирдамжууд нь Оюу Толгой төсөлд хамааралтай юм.

ГШ 4: Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүйн байдал

Төслүүд нь хэдийгээр орон нутгийн иргэдэд олон эерэг ашиг тусыг авчирдаг ч, хүн амын байнгын буюу түр зуурын өөрчлөлт; түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний тээвэрлэлт; барилгын ажил, үйлдвэрлэл ба үйл ажиллагааны зогсолт; осол аварь, байгууламжийн нуралт болон хорт бодисын алдагдал гэх мэт аюул эрсдэлүүдийн боломжийг бас ихэсгэдэг. Энэ гүйцэтгэлийн шаардлага нь төсөл хэрэгжүүлэгчийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүйн байдлын сөрөг нөлөөлөл болон эрсдэлүүдийг тодорхойлох, түүнээс зайлсхийх эсвэл түүнийг хамгийн бага хэмжээнд байлгах зэрэг үүрэг хариуцлагуудыг тогтоож өгдөг.

ГШ 5: Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн суурьшуулалт ба эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт

Зохих ёсны менежментгүй хийсэн албан нүүлгэн суурьшуулалт нь нөлөөлөлд өртсөн ард иргэдэд урт хугацааны хүндрэл, гачигдлуудыг авчрахаас гадна, хүлээн авсан нутаг орны байгаль орчин ба нийгэм эдийн засагт сөрөг нөлөөллүүд үүсгэдэг. Зарим тохиолдолд, муухан хэрэгжүүлсэн албадан нүүлгэн суурьшуулалт нь үйлчлүүлэгчийг хуулийн хариуцлагад татагдахад хүргэдэг. Энэхүү гүйцэтгэлийн шаардлагын зорилтууд нь:

- Албадан нүүлгэн суурьшуулалтаас зайлсхийх буюу хамгийн бага хэмжээтэй байлгах төслийн төлөвлөлтийн боломжит хувилбаруудыг судалж үзэх;
- Газрыг чөлөөлөх буюу хэрэглэх ба ашиглах боломжийг нь хязгаарлах зэрэг нөлөөлөлд өртсөн хүмүүст үзүүлэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулахын тулд: (i) эд хөрөнгөө алдсаны нөхөн төлбөрийг үнэлэн барагдуулах; ба (ii) нүүлгэн суурьшуулалтын ажиллагааг зохих ёсны нээлттэй хэлэлцүүлэг байдлаар явуулах бөгөөд нөлөөнд автагдаж байгаа хүмүүст мэдээлэл хүргэгдэж буйг баталгаажуулах;
- Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдийн амьжиргаа ба амьдралын түвшинг аж ахуй эрхлэх болон цалин хөлстэй ажил эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар сайжруулах буюу багадаа, төслийн өмнөх түвшинд нь аваачин сэргээн тэдний нийгэм, эдийн засгийн байдлыг тогтвортойгоор сайжруулах; ба
- Нүүж очсон газарт нь аюулгүй амьдрах орон байр барьж өгөх зэргээр нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүсийн амьдралын орчин нөхцлийг сайжруулах.

ГШ 6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хадгалан хамгаалах ба амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент

ЕСБХБ нь санхүүжилт авч байгаа төслүүд нь биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалан хадгалж байх хэрэгтэй хэмээн үздэг. Энэ зорилтууддаа хүрэхийн тулд ЕСБХБ нь олон улсын зохих хууль дүрэм ба конвенц болон холбогдох Европын Холбооны Зааврыг даган мөрдөж, зааварчилгаа болгодог:

- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалан хадгалах;
- Биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, хамгийн бага байлгах буюу бууруулах, боломжтой бол биологийн төрөл зүйлүүдэд хохирол учруулах бус харин ашиг тус авчрах зорилгоор их хэмжээний үлдэгдэл нөлөөллүүдийг нөхөн төлөх;
- Байгалийн нөөцийн тогтвортой менежмент болон ашиглалтыг дэмжих;
- Төслийн хэрэгжүүлэлт болон генетикийн нөөцийн ашиглалтаас үүдэн гарах ашиг орлогыг эрх тэгш, шударгаар хуваарилах;
- Компаниудын үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл, нэр төр болон өрсөлдөөний давуу талыг бизнесийн эрсдэл ба боломж болдгийнх нь хувьд биологийн төрөл зүйлүүдийн менежментийн тэргүүн туршлагыг ашигласнаар баталгаажуулж өгөх; ба
- Байгаль орчныг тогтвортой бусаар ашигласан газруудад амьжиргааны шинэ хувилбаруудыг санал болгодог биологийн төрөл зүйлүүдийн бизнесийн хөгжлийг хөхүүлэн дэмжих.

ГШ 7: Нутгийн уугуул иргэд

Төслийн нөлөөлөлд өртөх нутгийн уугуул иргэд байхгүй. Нутгийн малчид нь үндэс угсаа, соёл иргэншлийн хувьд Монгол улсын үндэстэн ястаны цөм хэсэг болсон халх монголчууд юм. Тэдний уламжлалт ахуй амьдралын хэв маягт эдийн засгийн хөгжил болон нийгмийн өөрчлөлтүүд нь дарамт шахалт үзүүлж байгаа тул энэхүү БОННБҮ-нд малчин ард иргэдийг “эмзэг бүлэг” хэмээн нэрлэсэн.

ГШ 8: Соёлын өв

Соёлын Өв нь түүхэн болон шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий мэдээллийн эх үүсвэр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн өв хөрөнгө ба хүмүүсийн соёлын онцлог байдал, зан үйл, уламжлал зэргийн нэгдэл байдаг учир чухал ач холбогдолтой зүйл юм. ЕСБХБ нь төслийн үйл ажиллагаанаас соёлын өвийг хамгаалж байхыг шаарддаг.

ГШ 9: Санхүүгийн зуучлагчид

Энэ төсөлд ямар нэгэн санхүүгийн зуучлагч байхгүй.

ГШ 10: Мэдээллийн ил тод байдал ба оролцогч талуудыг татан оролцуулах

ЕСБХБ нь төсөлд оролцогч талуудыг татан оролцуулах нь бизнесийн жишиг практик, байгууллагын соёлын амин чухал хэсэг нь гэж үздэг. Тухайлбал, ард иргэдийг үр дүнтэйгээр татан оролцуулах нь ард иргэдэд учруулах эрсдэл болон нөлөөллийн амжилттай менежментийн үндэс нь болдог төдийгүй ард иргэдэд өгөх ашиг тусыг дээшлүүлэх гол хүчин зүйл нь болдог. Энэ Гүйцэтгэлийн Шаардлагын зорилтууд нь:

- Төслийн нөлөөлөлд өртсөн буюу өртөж болох ард иргэд болон бусад сонирхож байгаа талуудыг тодорхойлох;
- Өөрсдөд нь нөлөөлөл үзүүлж болох байгаль орчин, нийгмийн асуудлууд дээр мэдээллийг нээлттэй хүргэж ач холбогдолтой хэлэлцүүлэг хийх зэргээр оролцогч талуудын оролцоог баталгаажуулах; ба
- Төслийн хэрэгжүүлэлтийн явцад оролцогч талуудын идэвхитэй оролцоог хангах замаар тэдэнтэй үр дүнтэй бүтээлч харилцааг үүсгэн дэмжих.

2.8.3 ЭЗХАХБ-ын Байгаль орчны нийтлэг хандлагуудын талаар болон албан ёсоор дэмжигддэг экспортын зээлүүдийн талаар өгсөн зөвлөмжүүд

ЭЗХАХБ-ын улс орнууд нь 2007 онд өөрсдийн засгийн газруудын экспортын зээлийн агентлагуудын зүгээс дэмжиж байгаа дэд бүтцийн төслүүд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудын дагуу явагдаж буйг баталгаажуулахын тулд тэдгээрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хандах нийтлэг хандлагыг бэхжүүлэхээр тохиролцсон. Засгийн газрын экспортын зээлийн агентлагууд нь ихэнхдээ хурдацтай хөгжиж буй эдийн засагт чиглэсэн зээлийн баталгаа, экспортын зээлийн даатгал болон шууд зээл олгох зэргээр дэмждэг.

Гол бүрэлдэхүүн хэсгүүд нь:

- Төслүүд, бүх тохиолдолд, тухайн төсөл хэрэгжиж буй улсынхаа байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөнө. Хэрвээ олон улсын холбогдох стандартууд нь тухайн улсынхаас илүү чанга хатуу байвал экспортын зээлийн агентлагууд нь тэдгээр стандартуудыг баримтлах ёстой.
- Холбогдох олон улсын стандартууд нь Дэлхийн Банкны Бүлгийн ба газар зүйн талаасаа боломжтой тохиолдолд, Бүсийн Хөгжлийн Банкуудынх байна. Гишүүн улсууд нь илүү өндөр түвшний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг загвар болгож болно, тухайлбал: Европын Хамтын Нийгэмлэг.
- Тогтворгүй төслүүдийн хувьд, экспортын зээлийн агентлаг нь байгаль орчны стандартуудын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд олон улсын стандартаас доогуур байгаа үзүүлэлтүүдийг шаардлагад нийцүүлэн өсгөх ёстой.

- Тогтворгүй төслүүдийн хувьд, экспортын зээлийн агентлагууд нь санхүүжилтийн эцсийн амлалтаа өгөхөөсөө 30 хоногийн өмнө Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг багтаасан байгаль орчны мэдээллийг нийтэд ил болгодог.

2.8.4 Экваторын зарчим

Экваторын зарчимд нэгдсэн улс төслийн арилжааны зээлдүүлэгчид байх магадлал өндөр байдаг.

Экваторын зарчим (ЭЗ) нь төслийн санхүүжилтийн нийгэм, байгаль орчинд үзүүлэх эрсдлийг тодорхойлох, үнэлэх болон удирдах сайн дурын үндсэн дээр тогтоогдсон, стандартууд юм. ЭЗ нь тогтвортой төслийн санхүүжилтийн санхүүгийн салбарын 'алтан стандарт' гэж тооцогддог.

Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ийн Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын Гүйцэтгэлийн стандартууд болон Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүйн ажиллагааны ерөнхий удирдамжуудад тулгуурласан Экваторын зарчим нь хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж буй байгууллага бүрийн хувьд тэдгээрийн дотоод үйл ажиллагааны нийгэм, байгаль орчны бодлого, дүрэм журам ба стандартын хүрээг тогтоож өгөх үүргийг гүйцэтгэдэг. Экваторын зарчмын санхүүгийн байгууллагууд (ЭЗСБ) нь Экваторын зарчмын нийгэм, байгаль орчны бодлого болон дүрэм журмыг биелүүлэхгүй байгаа эсвэл биелүүлэх чадваргүй төслүүдэд зээл олгодоггүй.

2.8.5 Стандарт Чартеред банкнаас уул уурхай ба металлургын салбарт санхүүжилт олгоход баримтлах байр суурийн талаарх мэдэгдэл

Стандарт Чартеред банкны уул уурхай ба металлургын салбарын үйлчлүүлэгчид нь холбогдох олон улсын, бүсийн болон үндэсний хуулиудыг мөрдөж ажиллах ёстой байдаг. Зохих ёсны стандартууд байхгүй эсвэл байгаль орчин, нийгэмд үзүүлэх боломжит нөлөөлөл нь их байх тохиолдолд, Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Гүйцэтгэлийн стандарт ба Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа зэрэг үйлдвэрлэлийн салбарууд уул уурхайд хамаарах удирдамжуудыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг загвар болгон ашиглах ёстой.

Стандарт Чартеред банк нь 2003 онд Экваторын зарчмыг хүлээн зөвшөөрснөөр тус банкны бүхий л төслийн санхүүжилт болон зөвлөх үйл ажиллагаануудад Экваторын зарчим болон Уул уурхай, металлургын салбарт баримтлах байр сууриа илэрхийлэх мэдэгдэл баримт бичгийг баримталдаг

Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө OTESIA@ot.mn хаягаар ирүүлнэ үү.